



Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын
Захирал бөгөөд тэргүүлэх аудитор
М.Давааням

Аудитын менежер:
З.Ариунзаяа

Ахлах аудитор:
Б.Долгорсүрэн

Аудитор
Д.Баатархуяг
М.Гүнжмаа

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар 262451,
дугаарын утас, 323266 дугаарын
факсаар харилцана уу.

Уг тайланг **ҮАГ-ын Веб
сайтаас** үзнэ үү.
www.audit.mn

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-3,
Улаанбаатар-15160
Монгол Улс
www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	2
Хүснэгт, дүрслэлийн жагсаалт.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....	3
Ерөнхий мэдээлэл	4
Бүлэг 1. МҮОНРТ-ийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	5
<i>МҮОНРТ-ийн үйл ажиллагаа хуулиар тодорхойлсон зорилго, үндсэн зарчимд нийцэж байна.....</i>	5
<i>МҮОНРТ дэвшүүлсэн зорилго, хуулиар тодорхойлсон чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлж байна</i>	6
<i>Үндэсний зөвлөл хуулиар тодорхойлсон бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч гишүүдийн идэвх, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.....</i>	9
<i>МҮОНРТ-ийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.</i>	10
Бүлэг 2. МҮОНРТ-ийн санхүүгийн хөрөнгө нөөцийн төлөвлөлт, үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.	12
<i>Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг хуулийн дагуу төлөвлөж, бүрэн төвлөрүүлээгүй байна. .</i>	12
<i>Үйл ажиллагааны орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна</i>	14
<i>Эдийн засагч нарын ажлын уялдаа, холбоо муу байгаагаас үйл ажиллагааны зардлыг тооцоо судалгаагүйгээр төлөвлөж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй байна .</i>	15
<i>Санхүүгийн хөрөнгө, нөөцийн үр ашгийг сайжруулах шаардлагатай байна</i>	17
<i>Бүтэц, зохион байгуулалтыг удаа дараа өөрчилснөөс үйл ажиллагааны тогтворгүй байдлыг бий болгож, салбарын батлагдсан цалингийн төсөв хэтрэх эрсдэлийг үүсгэсэн байна</i>	18
Дүгнэлт.....	21
Зөвлөмж	22
МҮОНРТ-ээс ирүүлсэн санал	23
Үндэсний аудитын газрын тайлбар.....	28
Хавсралтууд.....	34
Тайланг баталгаажуулсан тушаал	35



Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгт, дүрслэлийн жагсаалт

№	Тайлбар
Хүснэгт № 1	МҮОНРТ-ийн 2017 оны нэвтрүүлгийн цагийн гүйцэтгэлийн судалгаа
Хүснэгт № 2	Үзэгчдээс авсан судалгааны нэгтгэл
Хүснэгт № 3	МҮОНРТ-ийн 2017 оны радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний судалгаа
Хүснэгт № 4	Улаанбаатар хотын хэрэглэгчдээс төвлөрүүлэх радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний тооцоо
Хүснэгт № 5	МҮОНРТ-ийн 2017 оны орлогын судалгаа
Хүснэгт № 6	МҮОНРТ-ийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн
Хүснэгт № 7	Эдийн засагч нарын ажлын байрны гол үйл ажиллагааны судалгаа
Хүснэгт № 8	МҮОНРТ-ийн 2017 оны орон тооны судалгаа
Хүснэгт № 9	МҮОНРТ-ийн 2017 онд орон тоог нэмэгдүүлсэн судалгаа
Хүснэгт № 10	Цалингийн санг 2017 онд хэтрүүлсэн салбарын судалгаа
Дүрслэл № 1	Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжийн хөлс
Дүрслэл № 2	Урамшууллын судалгаа



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө, сэдэв батлах тухай” 2018 оны А/06 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилтыг дэвшүүлж, дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- МҮОНРТ-ийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
- МҮОНРТ-ийн санхүү, хөрөнгө, нөөцийг зохих ёсоор бүрдүүлж, үр ашигтай удирдаж байгаа эсэх.

Аудитад Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын хамрах хүрээ

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд дурдсан аудитын арга зүйг мөрдөж аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын арга зүй

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль;
- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн дүрэм;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн хөдөлмөрийн дотоод журам;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол;
- бусад холбогдох дүрэм, журмууд;
- Бусад холбогдох хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав.

Аудитад ашигласан шалгуур

Хүндрэл бэрхшээл

Төсвийн байнгын хороо аудитыг 1 сарын хугацаанд гүйцэтгэхээр аудитын сэдвийг баталсан тул талбарын үе шатны ажлыг 10 хоногт багтаан хийхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хамрагдах эрсдэлтэй асуудлыг түүвэрлэж үзсэн, цаг хугацааны боломжгүй байдлаас шалтгаалан өмнөх оны санхүүгийн тайлангийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа хийж амжаагүй болно.



Ерөнхий мэдээлэл

Радио нэвтрүүлгийн үйл ажиллагаа 1934 онд бий болсон боловч Монголын үндэсний телевиз 1967 онд үүсэн байгуулагдаж, телевизийн нэвтрүүлгийн үйл ажиллагааг эхлүүлснээр Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэс суурь тавигдсан байна.

Улсын Их Хурлаас 2005 онд “Олон нийтийн радио телевизийн тухай хууль”-ийг баталж, Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 241 дүгээр тогтоолоор Монголын радио, Монголын үндэсний телевизийн үйл ажиллагааг нэгтгэсэн Радио телевизийн хэрэг эрхлэх газрыг татан буулгаж, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийг байгуулсан байна.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз 2017 онд телевизийн 2 сувгаар 12533 цагийн, радиогийн 3 сувгаар 13855 цагийн нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн бөгөөд Монголын дуу хоолой радио Монгол, Орос, Хятад, Япон, Англи зэрэг 5 хэл дээр нэвтрүүлгээ цацаж байна.

МҮОНРТ-ийн удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн, УИХ 7 хүн, Засгийн газар 4 хүнийг тус зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, УИХ-ын тогтоолоор баталдаг байна.

Үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор 2017 онд улсын төсвөөс 6.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 5.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт авсан бол үндсэн үйл ажиллагааны орлогоор 10.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг нэмж бүрдүүлсэн байна.

Ерөнхий захирал нь эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, холбогдох бусад харилцааг зохицуулсан “Хөдөлмөрийн гэрээ”-г Үндэсний зөвлөлтэй байгуулсны үндсэн дээр МҮОНРТ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна.



Бүлэг 1. МҮОНРТ-ийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

МҮОНРТ-ийн үйл ажиллагаа хуулиар тодорхойлсон зорилго, үндсэн зарчимд нийцэж байна

1.1. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална” гэж заасны дагуу улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг техникийн болон мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж нийтийн хүртээл болгож байна.

1.2. МҮОНРТ үндэсний хэмжээнд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгох үндсэн зорилгоо хэрэгжүүлж, 2017 онд нийт 26.4 мянган цаг буюу 1,583.3 мянган минутын хөтөлбөр бэлтгэн радиогийн 3, телевизийн 2 сувгаар дамжуулжээ. Үүнээс 4135 минутын нэвтрүүлгийг МҮОНРТ-ийн 50 жилийн ойд зориулан бэлтгэсэн байна.

Хүснэгт № 1. МҮОНРТ-ийн 2017 оны нэвтрүүлгийн цагийн гүйцэтгэлийн судалгаа

№	Үйл ажиллагааны чиглэл	Сувгийн нэр	Нэвтрүүлсэн	
			Цаг	Минут
1	Үндэсний хэмжээнд радиогийн өргөн нэвтрүүлэг	Радио 1	6207	372420
		Р3 радио	5824	349440
2	Үндэсний хэмжээнд телевизийн өргөн нэвтрүүлэг	Үндэсний олон нийтийн телевиз	6286	377160
		Монголын мэдээ суваг	6247	374820
3	Гадаад хэлээр явуулах радио, телевизийн нэвтрүүлэг	Монголын дуу хоолой	1824	109440
ДҮН			26388	1583280

Эх сурвалж: МҮОНРТ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

1.3. Ерөнхий захирал Олон нийтийн радио, Үндэсний Телевиз, Монголын мэдээ сувгуудын сүлжээг батлан тогтвортой мөрдүүлж, хөтөлбөрийг долоо хоног бүрийн Баасан гарагт Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нийцүүлэн хяналт тавьж, баталж байна.

1.4. МҮОНРТ-ийн 2017 оны 1 дүгээр сараас эхлэн хөтөлбөрийн шинэчлэлт хийх төлөвлөгөөний дагуу өмнөх оны хөтөлбөрийн бодлогын агуулгыг шинэчилж, нийт 21 шинэ нэвтрүүлгийг сүлжээнд тусгажээ. Тухайлбал:

- “Монголын мэдээ” сувгийн бүтцэд шилжиж, нийгэм, байгаль орчин, хүнс, ХАА-н чиглэлийн агуулга бүхий нэвтрүүлгүүд, цаг үеийн ярилцлага, асуудал дэвшүүлсэн хэлэлцүүлгүүд нэмэгдсэн.
- Улс төр, хууль эрх зүй, өв уламжлал, цэнгээнт жанрын 10 орчим нэвтрүүлгээр сүлжээг баяжуулж, хэт урт сунжирсан нэвтрүүлгүүдийн цагийг багасгах, чанарыг сайжруулах, зарим шаардлагагүй нэвтрүүлгийг сүлжээнээс хассан.

1.5. “Максима медиа” компанийн телевиз үзэлтийн 2017 оны судалгааны нэгдсэн тайлангаас харахад хөтөлбөрийн шинэчлэлт хийгдэж, 2017 оны 4 дүгээр сараас эхлэн орой бүр шууд нэвтрүүлгүүдийг сүлжээнд нэмснээр давталтын цаг багасч, оргил цагаар үзэгчдийн хандалт нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



1.6. МҮОНРТ-ээс 2017 оны 9 дүгээр сард Сүхбаатарын талбайд зохион байгуулсан нээлттэй өдөрлөгийн үеэр үзэгчдээс ямар төрлийн нэвтрүүлгийг илүү их үздэг, цаашид ямар төрлийн нэвтрүүлгийг үзэх хүсэл сонирхолтой байдаг, олон нийтийн телевиз хуулиар хүлээсэн үүрэг зорилгоо хэрхэн биелүүлдэг талаар тэдний үнэлэмж, хүлээлтийг тандах зорилгоор 499 хүнийг хамруулан судалгаа явуулсан байна.

Хүснэгт № 2. Үзэгчдээс авсан судалгааны нэгтгэл

№	Үзүүлэлт	Үнэлгээ /хувьар/			
		Сайн	Дунд	Муу	Мэдэхгүй
1	Хараат бус, бие даасан байдлаар ажиллах	45.7	29.9	7.8	16.6
2	Олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх	51.7	24.8	5.0	18.4
3	Иргэдэд бодит, шуурхай мэдээлэл түгээх	68.1	15.0	4.8	12.0
4	Улс төрийн албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагын бус олон нийт, үндэсний эрх ашгийг дээдлэх	51.5	25.9	7.4	15.2
5	Олон янзын агуулга бүхий өргөн хүрээний мэдээлэл түгээх	50.1	27.7	6.2	16.0

Эх сурвалж: МҮОНРТ-ийн өдөрлөгийн үеэр үзэгчдээс авсан санал асуулгын нэгтгэл

1.7. Иргэд, олон нийтээр Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан дээрх үндсэн 5 үзүүлэлтээр үнэлгээ хийлгэхэд МҮОНРТ үүргээ сайн биелүүлж байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь үнэлж, иргэд, олон нийтэд бодит, шуурхай мэдээлэл түгээх байдлыг 68.1 хувь нь сайн гэж үнэлсэн байна.

1.8. Санал асуулгын дүнгээр “Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж чаддаг”, “МҮОНРТ илүү мэргэжлийн түвшинд ажилладаг” гэсэн үнэлгээ өгсний зэрэгцээ үзэгчид мэдээ, мэдээлэл, боловсрол сургалт, шинжлэх ухаан танин мэдэхүйн нэвтрүүлгийг илүү их үзэхийг хүсдэг талаар санал өгсөн байна.

МҮОНРТ дэвшүүлсэн зорилго, хуулиар тодорхойлсон чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлж байна

1.9. МҮОНРТ 2017 онд “Олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн нийгмийн оюун санааны хөтөч Үндэсний агууламжтай уран бүтээлийн мэргэжлийн байгууллага байх” эрхэм зорилго, түүний хүрээнд дэвшүүлсэн хөгжлийн зорилго, зорилтуудад тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлжээ.

1.10. “Бодлого төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хүний нөөцийг чадавхижуулах” хөгжлийн зорилгын хүрээнд 2017 оныг “Сайн засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх жил болгон зарлаж, төсөв санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан 10 салбар нэгжээр ангилан 227 ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

1.11. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад удирдлага, менежментийн баг өөрчлөгдсөн, Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголоор МҮОНРТ-ийн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, их засварт 8.4 тэрбум төгрөг батлагдсан, радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 10 бүс нутгийн цахилгаан түгээх станцтай байгуулсан гэрээг шинэчилж, шимтгэлийн хувь хэмжээг бууруулсан, байгууллагын дотоод зохион байгуулалтад зарим өөрчлөлт орсон, хөтөлбөрийн бодлогын шинэчлэл хийгдсэн зэргийг үндэслэн 7



салбар нэгжээр 228 ажлыг хийхээр үйл ажиллагааны төлөвлөгөөг тодотгосон байна.

1.12. “МҮОНРТ-ийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хийсэн үнэлгээгээр МҮОНРТ-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 87.7 хувь буюу “сайн” гэж үнэлсэн байна.

1.13. МҮОНРТ 2017 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр”-ийн бодлогыг хэрэгжүүлэх, олон улсын ижил төстэй байгууллага, цаг үеийн шаардлагатай хөл нийлүүлэх, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, чанартай төсөл хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, хөтөлбөрийн олон талт байдлыг ханган ажиллахын зэрэгцээ Монгол улсад телевизийн салбар үүсч хөгжсөний 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, Сайн засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тусгай сургалтууд зохион байгуулах, Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагааг шууд дамжуулах зэрэг онцлог үйл явдлуудыг амжилттай зохион байгуулсан байна.

1.14. Үндэсний зөвлөлийн шийдвэрийг үндэслэн албан тушаалын үндсэн цалинг 2017 оны 3 дугаар сарын 1-нээс 52.0 мянган төгрөгөөр, мөн оны 12 дугаар сарын 1-нээс 32.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, Олон нийтийн телевизийн 3-р суваг буюу “MNB Спорт суваг”, 4-р суваг буюу “MNB world” сувгийг тус тус байгуулж, 2018 оноос эхлэн эфирээр цацахад бэлэн болгосон байна.

1.15. Сайн засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Компанийн засаглалын Үндэсний Зөвлөл”-тэй хамтран байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журамд дүн шинжилгээ хийснээр 5 журамд нэмэлт өөрчлөлт оруулж, 7 журмыг шинээр батлан хэрэгжүүлж байна.

1.16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар МҮОНРТ-ийн дулааны шугам солих, Студи 600, Студи 150-ын тоног төхөөрөмжийг өндөр тодролын HD форматад шилжүүлэх, орчин үеийн гэрэлтүүлгийн төхөөрөмжөөр бүрэн тоноглох, хальсгүй технологид шилжүүлэх ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

1.17. Энэ асуудлыг “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийж буй гүйцэтгэлийн аудитад хамруулан шалгаж байгаа болно.

1.18. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17.1.1-д заасан радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг “Цахилгаан түгээх сүлжээ” компаниудаар дамжуулан хураан төвлөрүүлэх гэрээг шинэчлэн үйлчилгээний шимтгэл 25 хувь байсныг бууруулж, 15-23 хүртэл хувь болгон 14 компанитай гэрээг шинэчлэн байгуулснаар радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс өмнөх оноос 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.19. МҮОНРТ-ийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах бодлогын хүрээнд байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, төсөл хөтөлбөр, нэвтрүүлгийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор Англи хэл дээр 1500, Монгол хэл дээр 3000 ширхэг танилцуулгыг бэлтгэн олон нийтийн хүртээл болгож, 2017 оны 9 дүгээр сард Сүхбаатарын талбайд олон нийтийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, дараах үйл ажиллагааг явуулсан байна. Тухайлбал:



- Олон нийтийн санал асуулга явуулах,
- Спортын тэмцээн уралдаан явуулах,
- Хамтлаг дуучдын шоу тоглолт хийх,
- Телевизийн түүхэн үйл явдлын үзмэр гаргах,
- Нийтлэл, нэвтрүүлгийг сурталчилж, МҮОНТ-ийн шууд нэвтрүүлэгт олон нийтийг оролцуулах.

1.20. Монгол Улсад телевизийн салбар байгуулагдсаны 50 жилийн ой, түүнийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах арга хэмжээ, телевизийн салбарын үүсэл хөгжлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэр дундаа хамгийн олон хандалттай мэдээллийн сайтууд, фэйсбүүк хуудас зэрэг онлайн мэдээллийн хэрэгслийг ашиглах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг хийж гүйцэтгэжээ.

1.21. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2017 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотын утааг бууруулах чиглэлээр Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй төрөл бүрийн цахилгаан халаалтын худалдаа эрхлэгч, дулааны алдагдалгүй болгох бүтээгдэхүүн болон эко төхөөрөмж, агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөх технологийн шийдлүүд, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн байгууллагуудыг танилцуулах, тэднийг нэг дор цуглуулж иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, сонголт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор үзэсгэлэн зохион байгуулж, нийт 4000 гаруй иргэнийг хамруулсан.

1.22. Уран бүтээлчдийн чадавхи, өрсөлдөх чадвар, нэвтрүүлгийн агуулга чанарыг сайжруулах, баяжуулах, төрөлжүүлэх, гадаадын ижил төстэй хэвлэл мэдээллийн байгууллагаас контент авах, солилцох, байгууллагын нэр хүндийг олон улс, бүс нутагт таниулах, өсгөх зорилгоор гадаад хамтын ажиллагааг идэвхтэй явуулж, хилийн чанадад зохион байгуулсан МҮОНРТ-д ач холбогдолтой олон улсын дээд хэмжээний уулзалт, форум, семинар, сургалтад удирдлага, уран бүтээлчид, ажилтнуудыг оролцуулж, дараах үр дүнг бий болгосон байна. Тухайлбал:

- ОХУ-ын Спутник, Central Partnership болон Совтелеэкспорттой хамтран ажиллах гэрээ байгуулж, мэдээ, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн,
- Central Partnership-ээс 98 анги, Совтелеэкспорт /Россия/-аас 61 ангитай уран сайхны киног авч, орчуулж, үзэгчдийн хүртээл болгох ажлыг эхлүүлсэн.

1.23. Байгууллагын доторх хэв журам, дотоод сахилга бат, аюулгүй ажиллагааг хангах үүднээс гадна үүдний /хойд болон төв/ хаалгууд, мөн коридор, студи, эфир, дуу бичлэг, тайзны агуулах, монтажны өрөөнүүдийн хаалгуудыг автоматжуулж, бүрэн ашиглалтад оруулж, нийт ажилтнууд смарт карт бүхий нэвтрэх ажлын үнэмлэхтэй болгосноор дотоод зохион байгуулалт эмх цэгцтэй болсны зэрэгцээ ажиллагсдын цаг бүртгэлийн үйл ажиллагаанд дэвшил гарсан байна.

1.24. МҮОНРТ-ийн байранд хэсэгчилсэн засвар хийх, тавилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх, өрөө, тасалгааны ашиглалт зохион байгуулалтыг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн нь үр дүнтэй болжээ.

1.25. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, байгууллагын соёл, ажиллагсдын хамтач уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэгдсэн олон ажлуудыг хийж, байгууллагын хувьд нэн шаардлагатай, ажиллагсдын тулгамдсан асуудал болох хүүхдийн цэцэрлэг байгуулах асуудлыг шийдвэрлэж чадсан байна.



Үндэсний зөвлөл хуулиар тодорхойлсон бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч гишүүдийн идэвх, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна

1.26. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д Үндэсний зөвлөл нийт 15 гишүүнтэй байхаар заасан боловч 2017 онд гишүүн С.Санасэр АНУ-д суралцахаар явсан шалтгааны улмаас одоогоор 14 гишүүнтэй ажиллаж байна.

1.27. Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдсон бүх гишүүд хуулийн шаардлагад нийцсэн бөгөөд УИХ-аас сонгогдсон Л.Пүрэвдорж, Д.Гоошоохүү, С.Мягмар, Засгийн газраас сонгогдсон А.Арман нарын 4 гишүүний бүрэн эрхийн хугацаа 2018 оны 9 дүгээр сарын 18-нд дуусахаар байна.

1.28. Бүрэн эрхийн хугацаа 2018 оны 1 сарын 20-ны өдөр дуусгавар болсон тул МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн дарга Б.Энхмандахыг 2018 оны 01 дүгээр тогтоолоор улируулан сонгожээ.

1.29. Үндэсний зөвлөл хуулинд заасан бүрэн эрхийн хүрээнд 2017 онд МҮОНРТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, Хяналтын зөвлөл болон Өргөдлийг шалгах хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох, Ерөнхий захиралд нэр дэвшүүлэх, томилох журмыг батлах, түүнтэй гэрээ байгуулах, байгууллагын 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хэлэлцэж батлах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

1.30. Үндэсний зөвлөл 2017 онд 14 удаа хуралдаж, нийт 64 тогтоол гаргасан байна. Хуралдаанд хэлэлцсэн асуудлаас хамааран олон нийтэд мэдээлэх шаардлагатай гэж үзсэн 7 хуралдааны явц шийдвэрийн талаар мэдээлсэн байна.

1.31. Хуралдааны ирц ихэнхдээ 73.3 хувиас дээш байгаа боловч нийт гишүүдийн 46.7 хувь буюу 7 нь тодорхой шалтгааны улмаас 3-7 удаагийн хуралдаанд суугаагүй байна.

1.32. Цаашид Үндэсний зөвлөлийн гишүүдийн идэвх оролцоо, хариуцлагыг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

1.33. Өргөдлийг шалгах хороо 2017 онд 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, нэвтрүүлгийн агуулгатай нийт 4 өргөдөл хүлээн авч 100 хувь барагдуулжээ.

1.34. Өргөдлийг шалгах хорооны ажиллах журамд 2018 оны 08 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, тус хороог 5 гишүүнтэй байна гэсэн заалтын дагуу Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Оюун-Эрдэнэ, Б.Галаарид нарыг тус хорооны гишүүнээр томилжээ.

1.35. Үндэсний зөвлөлийн Хяналтын зөвлөл, Өргөдлийг шалгах хороо 2017 оны ажлын тайланг тусгайлан гаргаагүй байна.

1.36. Үндэсний зөвлөлийн 2017 оны хуралдааны тэмдэглэлийг гарын үсэг зурж албажуулаагүй, архивлан үдээгүй, Хяналтын зөвлөлийн зарим дүгнэлт, тэмдэглэл гарын үсгийн иж бүрдэл хангагдаагүй байсан зөрчлийг илрүүлж, аудитын явцад бүрэн арилгуулав.



МҮОНРТ-ийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

1.37. Үндэсний зөвлөл нь МҮОНРТ-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг Хяналтын зөвлөл, түүний удирдлагад ажиллаж буй 2 дотоод аудиторoor дамжуулан хэрэгжүүлж байна.

1.38. Үндэсний зөвлөл орон тооны бусаар ажилладаг Хяналтын зөвлөлийн удирдлагад орон тооны 2 дотоод аудиторыг 2016 оноос эхлэн ажиллуулсан нь хяналтын шуурхай байдал, үр дүнг дээшлүүлэх, эрсдэлийг удирдахад чухал үр нөлөөтэй шийдэл болжээ.

1.39. Хяналтын зөвлөл 2017 онд нийтдээ 16 удаа хуралдаж, 14 дүгнэлт гаргаж, Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

1.40. Үндэсний зөвлөл нь Хяналтын зөвлөлийн дүгнэлтэд зарим тохиолдолд ач холбогдол өгөөгүй, шийдвэртээ тусгаагүй нь холбогдох асуудлыг шийдвэрлэхэд эрсдэл үүсгэж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна. Тухайлбал: МҮОНРТ-ийн дэргэд хүүхдийн цэцэрлэг байгуулах зардал 2017 оны төсөвт тусгагдаагүй, сонгон шалгаруулалтын материалыг бүрэн эхээр нь үзэх шаардлагатай тул уг асуудлыг хойшлуулахаар Хяналтын зөвлөл дүгнэлт гаргасан байхад хүлээн аваагүй байна.

1.41. Дотоод аудитын албанаас 2017 онд МҮОНРТ-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нийт 6 удаа аудит хийж, тайланг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

1.42. Дотоод аудитаар өгсөн нийт 29 зөвлөмжийн биелэлт 70.3 хувьтай, үүний дотор 50 түүнээс доош хувийн биелэлттэй 9 зөвлөмж байгаагаас үзэхэд гүйцэтгэх удирдлагын зүгээс илэрсэн зөрчил дутагдлыг арилгах асуудалд ажил хэрэгч, шуурхай хандаагүйгээс тухайн зөрчил бүрэн арилахгүй байх, хугацаа алдах магадлалтай байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлийг бий болгож байна.

1.43. Үндэсний зөвлөлөөс МҮОНРТ-ийн хэмжээнд дагаж мөрдөх зарим журмыг төрийн хууль тогтоомжид нийцүүлэн батлан мөрдүүлж байгаа ч Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар тодорхойлсон статуст нийцсэн хуулийн зохицуулалт байхгүй байна.

1.44. Энэ нь аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал: Улсын төсвийн дэмжлэг, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төрийн өмчид бүртгэх эсэх, санхүүгийн тайланг ТББ-д мөрдөх журмын дагуу гаргаж буй нь зөв эсэх зэрэг асуудлыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлүүлэх шаардлага байгааг харуулж байна.

1.45. Олон нийтийн телевиз нь “public” буюу олон нийтийн байгууллага тул Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж буй төрийн болон төрийн өмчит байгууллагад мөрдөгдөх бүх хууль, тогтоомжийг мөрдөхөд харшлах зүйлгүй бөгөөд худалдан авалт, бүртгэл, тайлагнал, бусад асуудлыг төрийн байгууллагад мөрдөх хууль, тогтоомжид нийцүүлэх нь зүйтэй байна.



1.46. МҮОНРТ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд жил бүр өөр өөр аудитын компанийг сонгон шалгаруулж аудит хийлгэсэн байна.Тухайлбал: МҮОНРТ-ийн 2015 оны санхүүгийн тайланд “Координат аудит ХХК”, 2016 онд “Их Монгол Хөлөг аудит” ХХК, 2017 онд “И ЭС ЭС ЭС аудит” ХХК компани аудит хийсэн байна.

1.47. Сонгосон нэг аудитын компаниар давтан аудит хийлгэх нь байгууллагыг судлахад цаг алдахгүй, тухайн жилд үзэж амжаагүй зүйлийг дараа жилд нь үзэх боломжийг олгодог, зөвлөмжийн үр дүнг тооцоход тодорхой болж, гүйцэтгэл үр дүнг үнэлэхэд илүү үр дүнтэй байдаг.




Бүлэг 2. МҮОНРТ-ийн санхүүгийн хөрөнгө нөөцийн төлөвлөлт, үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг хуулийн дагуу төлөвлөж, бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.1. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг нийтийн антенн, өөрийн сансрын хүлээн авах, нэвтрүүлэх станц, кабелийн телевизийн шугамтай эсэхээс үл хамааран айл өрхөд болон байгууллага, аж ахуйн нэгжид радио-хүлээн авагч, телевизор тус бүрээр тооцон ногдуулна” гэж заасан байна.

2.2. Дээрх заалтыг үндэслэн Засгийн газрын¹ 2000 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан төвлөрүүлэх журам”, Үндэсний зөвлөлийн 2001 оны 8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Радио, телевизийн хэрэг эрхлэх газар /хуучин нэрээр/-ын даргын 2001 оны 403 дугаар тушаалаар Улаанбаатар хотод айл өрх 1100, албан байгууллага 1650, аймгийн төвд айл өрх 850, албан байгууллага 1200, сум, багийн төвд айл өрх 600, албан байгууллага 600 төгрөг байхаар тогтоосон байна.

2.3. МҮОНРТ-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг үндэслэн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх талаар холбогдох тооцооллыг хийж, Үндэсний зөвлөлийн 2013 оны 52 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газарт, 2014 оны 66 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайдад тус тус хүргүүлсэн боловч өнөөг хүртэл шинэчлээгүй байна.



Эх сурвалж: МҮОНРТ-ийн 2015, 2016, 2017 оны санхүүгийн тайлан

2.4. Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжийн орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 2015 онд 1,511.9 сая төгрөгөөр, 2016 онд 1,824.2 сая төгрөгөөр давсан байхад гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхгүйгээр өмнөх оны төлөвлөгөөг 2016 онд 105.9 сая төгрөгөөр, 2017 онд 109.4 сая төгрөгөөр өсгөн төлөвлөжээ.

2.5. Аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн 2017 оны радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд 3,745.9 сая төгрөгийн

¹18.2. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.



төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 6,497.4 сая төгрөгийг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 2,751.5 сая төгрөгөөр буюу 73.5 хувиар давуулсан байна.

Хүснэгт № 3. МҮОНРТ-ийн 2017 оны радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний судалгаа

Үзүүлэлт	(сая төгрөгөөр)	
	мөнгөн дүн	эзлэх хувь
A	1	2
Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ	3,825.1	58.9
Орон нутаг	2,575.5	39.6
Албан байгууллага	51.5	0.8
Сууц өмчлөгчдийн холбоо	45.2	0.7
Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний дүн	6,497.4	100.0

Эх сурвалж: МҮОНРТ-ийн 2017 оны санхүүгийн тайлан

2.6. Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжийн 60.4 хувийг Улаанбаатар хотын айл өрх, албан байгууллагаас, 39.6 хувийг орон нутгийн айл өрхөөс тус тус бүрдүүлсэн байна.

2.7. Үндэсний статистикийн хорооноос гаргасан зөвхөн Улаанбаатар хот дахь кабелийн телевиз хэрэглэгчдийн тоонд² суурилан одоогийн мөрдөж байгаа тарифаар³ тооцож үзэхэд радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсөөр төвлөрүүлэх боломжтой орлого 5,5522.8 сая төгрөг байгаа нь МҮОНРТ-ийн 2017 онд Улаанбаатар хотын хэрэглэгчдээс төвлөрүүлсэн 3,921.9 сая төгрөгийн орлоготой харьцуулахад 1,600.9 сая төгрөгөөр илүү байна. (Хүснэгт № 4)

Хүснэгт № 4. Улаанбаатар хотын хэрэглэгчдээс төвлөрүүлэх радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний тооцоо

(сая төгрөгөөр)					
Он	Улаанбаатар хотын кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо	Тариф /төгрөгөөр/	Төвлөрүүлэх боломжтой орлого	МҮОНРТ-ийн төвлөрүүлсэн орлого	алдсан боломж
2016	384356	1100	5,073.5	3,494.8	1,578.7
2017	418397	1100	5,522.8	3,921.9	1,600.9

Эх сурвалж: Аудитын тооцоолол

2.8. Энэ нь МҮОНРТ Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн өрх, аж ахуйн нэгж, байгуулагуудаас радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг бүрэн аваагүй байх эрсдэлтэй болохыг харуулж байна.

2.9. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3⁴-д заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагад нийцүүлэлгүй өмнөх оны төлөвлөгөөг тооцоо судалгаагүйгээр өсгөх хэлбэрээр төлөвлөсөн байна.

2.10. МҮОНРТ-ийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг хамрагдах боломжтой айл өрх, албан байгууллагын телевизийн тоо, нэгдсэн судалгаа, өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөж, хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

² Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2016

³ Радио, телевизийн хэрэг эрхлэх газар /хуучин нэрээр/-ын даргын 2001 оны 403 дугаар тушаалаар

⁴ 27.1.2. макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх; 27.1.3. төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх;



Үйл ажиллагааны орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна

2.11. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5⁵, “Төсвийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21⁶ дэх заалтыг үндэслэн 2017 онд 6,085.7 сая төгрөгийн улсын төсвийн төсвийн дэмжлэг, 5,272.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт авсан байна.

2.12. МҮОНРТ-ийн 2017 оны нийт орлогын эх үүсвэрийн 64.1 хувийг өөрийн үйл ажиллагааны орлогоор, 35.9 хувийг улсын төсвийн дэмжлэгээр бүрдүүлжээ. (Хүснэгт № 5)

Хүснэгт № 5. МҮОНРТ-ийн 2017 оны орлогын судалгаа

(мянган төгрөгөөр)

Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	нийт орлогод эзлэх хувь
А	1	2	3
Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс	3,745,896.7	6,497,374.5	38.3
Захиалгат нэвтрүүлгийн орлого	3,211,336.0	3,277,377.9	19.3
Түрээсийн орлого	377,131.3	501,699.7	3.0
Бусад орлого	327,600.0	330,565.3	1.9
Хандив тусламжийн орлого	-	260,909.5	1.5
МҮОНРТ-ийн үндсэн үйл ажиллагааны орлогын дүн	7,661,964.0	10,867,926.9	64.1
Улсын төсвийн дэмжлэг	6,085,861.2	6,085,861.2	35.9
Улсын төсвийн дэмжлэгийн нийт дүн	6,085,861.2	6,085,861.2	35.9
Нийт орлогын дүн	13,747,825.2	16,953,788.1	100.0
Нийт орлогод үндсэн үйл ажиллагааны орлогын эзлэх хувь	55.7	64.1	
Нийт орлогод улсын төсвийн дэмжлэгийн эзлэх хувь	44.3	35.9	

Эх сурвалж: МҮОНРТ-ийн 2017 оны санхүүгийн тайлан

2.13. Улсын төсвийн дэмжлэгийн хэмжээг 2016 онд 8,803.4 сая төгрөгөөр төлөвлөснийг 7,699.2 сая төгрөг, 2017 онд 8,308.6 сая төгрөгөөр төлөвлөснийг 6,085.9 сая төгрөг, 2018 онд 14,699.2 сая төгрөгөөр төлөвлөснийг 7,689.5 сая төгрөг болгон бууруулж, Сангийн яамнаас хянасан байна.

2.14. МҮОНРТ 2017 онд захиалгат нэвтрүүлгийн орлогоор 3,277.4 сая төгрөг, хөрөнгө түрээслүүлсний орлогоор 501.7 сая төгрөг, бусад орлогоор 330.6 сая төгрөг, хандивын орлогоор 260.9 сая төгрөг, нийт 4,370.6 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. (дэлгэрэнгүйг Хүснэгт № 5-аас үзнэ үү)

2.15. Нийт орлогын 19.3 хувийг захиалгат нэвтрүүлгийн орлого, 3 хувийг хөрөнгө түрээслүүлсний орлого, 1.9 хувийг бусад орлого, 1.5 хувийг хандивын орлого эзэлж байна.

2.16. МҮОНРТ-ийн удирдлагын зүгээс үйл ажиллагааны бусад орлогыг нэмэгдүүлэх, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах талаар санаачлага гарган ажилласны дүнд нийт орлогын төлөвлөгөөг 41.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

⁵ Улсын төсвийн дэмжлэг

⁶ “санхүүгийн дэмжлэг” гэж төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор олгох хөрөнгийг



2.17. МҮОНРТ 2017 онд 2,729.3 сая төгрөгийн захиалгат нэвтрүүлгийн орлого төвлөрүүлсний 529.1 сая төгрөг буюу 19.4 хувийг нь бартерын гэрээгээр бүрдүүлж, санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

2.18. Аудитын явцад цаг хугацааны хувьд боломжгүйгээс бартерийн гэрээгээр бүрдүүлсэн орлогыг нарийвчлан шалгаагүй тул МҮОНРТ-ийн Дотоод аудиторуд уг асуудлыг шалгахыг зөвлөж байна.

2.19. МҮОНРТ-ийн 50 жилийн ойн арга хэмжээнд 241.8 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, албан хаагчдаас шинээр нээгдсэн цэцэрлэгт 19.1 сая төгрөг, нийт 260.9 сая төгрөгийн хандивыг хүлээн авч, 224.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн боловч Үндэсний зөвлөлийн 2012 оны 13 дугаар тогтоолоор баталсан “МҮОНРТ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 6 дугаар бүлгийн 6.5 дахь хэсэгт заасны дагуу хандивын капиталаар бүртгээгүй байна.

2.20. Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны орлогыг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнд суурилан үндэслэлтэй төлөвлөж, өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Эдийн засагч нарын ажлын уялдаа, холбоо муу байгаагаас үйл ажиллагааны зардлыг тооцоо судалгаагүйгээр төлөвлөж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй байна

2.21. МҮОНРТ нь 2017 онд үйл ажиллагааны зардалд 15,046.0 сая төгрөгийг зарцуулж, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг 1,788.2 сая төгрөгийн ашигтайгаар тайлагнасан байна.

Хүснэгт № 6. МҮОНРТ-ийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн

(сая төгрөгөөр)

№	Зардлын ангилал	Гүйцэтгэл
А	Б	2
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		16,953.8
1	Төсөл хэрэгжүүлсний зардал	296.1
2	Цалин хөлс болон НДШ	7,883.7
3	Засвар, үйлчилгээний зардал	819.5
4	Ашиглалтын зардал	687.4
5	Түрээсийн зардал	74.3
6	Албан томилолтын зардал	293.7
7	Элэгдлийн зардал	991.9
8	Зар сурталчилгааны зардал	99.1
9	Харилцаа холбоо, шуудангийн зардал	66.8
10	Шатахууны зардал	215.0
11	Шагнал урамшууллын зардал	220.9
12	Зээлийн хүүгийн зардал	18.0
13	Уран бүтээлийн зардал	1,031.6
14	Бусад зардал	2,348.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		15,046.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		1,907.7
15	Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, алдагдал	(120.2)
16	Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг /алдагдал/	0.7
ТАЙЛАН ҮЕИЙН ЦЭВЭР ДҮН		1,788.2

Эх сурвалж: МҮОНРТ-ийн 2017 оны аудитлагдсан санхүүгийн тайлан



2.22. Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн ашигтай гарсан нь нэгдүгээрт, Үндэсний зөвлөлийн 2012 оны 13 дугаар тогтоолоор баталсан “МҮОНРТ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 6 дугаар бүлгийн 6.6.2 заасны дагуу тайлант жилд 2016 оны 2,3,4 дүгээр улирал болон 2017 оны нийт 1,128.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг бууруулан бүртгэсэн, хоёрдугаарт, нягтлан бодох бүртгэлийн аккруэл зарчмыг зөрчин өмнөх оны өрийг барагдуулахад шаардагдах эх үүсвэрийг зардалд тусгаж төлөвлөсөн, гуравдугаарт, төлөвлөсөн дараах уран бүтээлийн ажлууд хийгдээгүй зэргээс шалтгаалсан байна. Тухайлбал:

- ✚ Дэлхийн болон Монголын нийгмийг өөрчилсөн 108 шинэчлэл хөтөлбөр хийгдээгүй 42.0 сая төгрөг;
- ✚ Монгол хүн Монголын баялаг хөтөлбөр хийгдээгүй 20.0 сая төгрөг;
- ✚ “Тэнгэрийн их хөлгөн” цуврал хөтөлбөр хийгдээгүй 67.6 сая төгрөг.

2.23. МҮОНРТ-ийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын жилийн төсвийг зохиож, батлуулах чиг үүрэг бүхий нэгдсэн төсвийн эдийн засагч нь Байгууллагын хөгжлийн газарт, төсвийн гүйцэтгэлийг гаргах, санхүүгийн тайлан болон үйл ажиллагаанд шинжилгээ, судалгаа хийж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий эдийн засагч нь Санхүүгийн орлого, бүрдүүлэлтийн хэлтэст тус тус харьяалагдан уялдаа холбоогүй ажиллаж байна.

2.24. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2 тусдаа гаргаж, батлагдсан төсөвтэй уялдуулан гүйцэтгэлийг хянаагүйгээс төсвийг үндэслэлгүй төлөвлөж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнахгүй байх эрсдэлийг үүсгэсэн байна. Тухайлбал:

- ✚ Цалингийн төсвийг бэлтгэхдээ Дотоод аудиторуд болон Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын цалинг Үндэсний зөвлөлийн төсөвт оруулсан бол гүйцэтгэлийг гаргахдаа Захиргаа дэмжих салбарт оруулан тайлагнасан;
- ✚ Төсөл хөтөлбөрийн зардлыг капиталжих хэсэг болон шууд зардлыг нэгтгэн төлөвлөснөөс төсөл хөтөлбөрийн зардал хэмнэлттэй мэт тайлагнагдсан;
- ✚ Салбарын жилийн төсвийг мөнгөөр ба үр дүнгээр бэлтгэж, гүйцэтгэлээ зөвхөн үр дүнгээр гаргаж байгаагаас төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас хийгдээгүй ажлууд, хэмнэсэн болон хэтэрсэн шалтгааныг харах боломжгүй байна.

2.25. Эдийн засагч нарын ажлын байрны тодорхойлолтыг аудитын явцад судалж үзэхэд дараах гол үйл ажиллагаа давхардаж байна. Тухайлбал:

Хүснэгт № 7. Эдийн засагч нарын ажлын байрны гол үйл ажиллагааны судалгаа

Ажлын байрны гол үйл ажиллагаа		
№	Байгууллагын хөгжлийн газар харьяалагдаж байгаа нэгдсэн төсвийн эдийн засагч	Санхүү орлого бүрдүүлэлтийн хэлтэст харьяалагдаж байгаа эдийн засагч
1	Ажиллагсдын цалинг зохицуулах, Засгийн газрын гаргасан шийдвэр, Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрт суурилан ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх үндэслэлийн тооцоолж, холбогдох байгууллага удирдлагуудад танилцуулж, шийдвэрлүүлэх	Ажиллагсдын цалинг зохицуулах, Засгийн газрын гаргасан шийдвэр, Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрт суурилан ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх үндэслэлийг тооцоолж, холбогдох байгууллага удирдлагуудад танилцуулж, шийдвэрлүүлэх
2	Үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын жилийн төсөв зохиож, удирдлагад танилцуулан батлуулж, Сангийн яам, холбогдох байгууллагад оруулж, шийдвэрлүүлэх	Үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын жилийн төсөв зохиож, удирдлагад танилцуулан батлуулж, Сангийн яам, холбогдох байгууллагад оруулж, шийдвэрлүүлэх

Эх сурвалж: Эдийн засагч нарын ажлын байрны тодорхойлолт

2.26. Эдийн засагч нарын ажлын байрны тодорхойлолтод санхүүгийн тайлан болон үйл ажиллагаанд шинжилгээ хийж, судалгаа дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан боловч тус чиг үүргийг зөвхөн орлого, зардлын өсөлт,



бууралт болон төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүүг тооцоолох төдийгөөр хэрэгжүүлж, удирдлагын шийдвэр гаргахад нөлөөлөх хэмжээний иж бүрэн судалгаа, дүн шинжилгээ хийгээгүй, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тодорхойлоогүй байна.

2.27. Цаашид эдийн засагч нарын ажлын байрны үйл ажиллагааны давхардлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулж, үйл ажиллагааны төсвийг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд гүйцэтгэлийг гаргаж, гүйцэтгэлийн үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, үр ашгийг тооцож хэвших шаардлагатай байна.

Санхүүгийн хөрөнгө, нөөцийн үр ашгийг сайжруулах шаардлагатай байна

2.28. Аудитын явцад МҮОНРТ-ийн 2017 оны үйл ажиллагааны зардлаас түүвэрлэн шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

Урамшуулалтай холбоотой:

2.29. МҮОНРТ-ийн албан хаагчдад үндсэн болон нэмэгдэл цалин хөлснөөс гадна салбар тус бүрийн үйл ажиллагааны онцлог чиг үүргийн хүрээнд боловсруулан Ерөнхий захирлын тушаалаар баталсан дор дурдсан журмуудыг үндэслэн урамшуулал олгосон байна. Үүнд:

1. Дэмжих салбарын ажилтнуудын ажлын чанарыг үнэлэх, урамшуулал олгох журам;
2. Техникийн төвийн ажилтнуудын ажлын чанарыг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам;
3. Кино орчуулгын нэвтрүүлгийн албаны уран бүтээлчдийн ажлыг үнэлэх, чанарын шагнал урамшуулал олгох журам;
4. Тайз чимэглэлийн албанаас хийж гүйцэтгэсэн уран бүтээлд чанарын шагнал урамшуулал олгох журам;
5. Дууны найруулагч, нэвтрүүлгийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам;
6. Маркетингийн менежерүүдийн ажлын чанарыг үнэлэх, урамшуулал олгох журам;
7. ОНР-ийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам;
8. Үндэсний телевизийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам;
9. Монголын мэдээ телевизийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам;
10. МҮОНРТ-ээр нэвтрүүлэх зар сурталчилгаа болон нэвтрүүлгийг ивээн тэтгэх үйл ажиллагааг зохицуулах журмын 6 дугаар зүйл.

2.30. Уран бүтээл, чанар, төсөл хөтөлбөрийн урамшуулалд 2017 онд нийт 590.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.31. Ерөнхий захирал 2017 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн Б/422 дугаар тушаалаар “Захирлуудын зөвлөлийн гишүүд”-д урамшуулал олгох зорилготой “Дэмжих салбарын ажилтнуудын ажлын чанарыг үнэлэх, урамшуулал олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, нийт 38.5 сая төгрөгийг олгосон байна.





2.32. Тус журамд оруулсан нэмэлт заалтыг цаашид мөрдөн урамшууллыг олгох боломжтой байтал 2017 оны 1, 2 улирлын урамшууллын 31.0 сая төгрөгийг нөхөн олгож олон нийтийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

2.33. Маркетингийн менежерийн ажлын байрны тодорхойлолтод байгууллагын орлогыг дээшлүүлэх үндсэн чиг үүрэгтэй гэж заасан байтал маркетингийн менежерүүдэд ажлын байрны үндсэн үүргээ хэрэгжүүлсний төлөө нийт 24.4 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

2.34. “МҮОНРТ-ээр нэвтрүүлэх зар сурталчилгаа болон нэвтрүүлгийг ивээн тэтгэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3-т “Үйл ажиллагааны онцлог... зуучилсан ажил, үйлчилгээний төлбөрөөс дараах хувиар тооцож урамшуулал олгоно”, 6.6-д “Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэх, орлогыг нэмэгдүүлэхэд идэвх санаачлагатай ажилласан... ажилтнуудад ажил, үйлчилгээнээс олсон нийт орлогын 5 хувийг улиралд нэг удаа тооцож урамшуулал болгон хуваарилж болно” гэж заасан нь 6.3 дахь хэсгийг үндэслэн зуучийн урамшуулал авсан албан хаагчид 6.6 дахь хэсгийг үндэслэн давхар урамшуулал авах эрсдэлийг үүсгэж байна.

2.35. Цаашид урамшуулалтай холбоотой журмуудыг цэгцлэн боловсруулж, Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, олон нийтийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах шаардлагатай байна.

2.36. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 40 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, байгууллагын дэргэдэх хүүхдийн цэцэрлэг байгуулсан нь ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой, зөв зүйтэй ажил болжээ.

Бүтэц, зохион байгуулалтыг удаа дараа өөрчилснөөс үйл ажиллагааны тогтворгүй байдлыг бий болгож, салбарын батлагдсан цалингийн төсөв хэтрэх эрсдэлийг үүсгэсэн байна

2.37. Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.6 дах заалтыг үндэслэн Үндэсний зөвлөлийн 2016 оны 45 дугаар тогтоолоор МҮОНРТ-ийн зохион байгуулалтын бүтэц болон орон тооны дээд хязгаарыг 680 орон тоогоор батлан, хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий захирал Л.Нинжжамцад үүрэг болгосон байна.

2.38. Ерөнхий захирал нь 2017 онд Үндэсний зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр дараах тушаалуудыг гарган МҮОНРТ-ын бүтцийг өөрчилсөн байна. Үүнд:

- ✦ 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Зохион байгуулалтын бүтэц, ажил албан тушаалын жагсаалтад өөрчлөлт оруулах тухай” Б/87 дугаар тушаалаар ОНТ-ийн 3 дугаар сувгийн захирал болон Ерөнхий продюсерийн ажил, албан тушаалыг хасч, ОНТ-ийн 1 дүгээр сувгийн орон тоонд нэгтгэн “Спорт, эрүүл мэндийн нэвтрүүлгийн баг”-ийг байгуулсан;
- ✦ 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/40 дүгээр “МҮОНРТ-ийн Үндсэн үйлдвэрлэлийн нэгжүүдийн бүтэц, орон тоо, ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” тушаал гарган Зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн Уран сайхны удирдагчийн шууд удирдлагад харьяалагдаж байсан Кино орчуулгын алба, Дууны найруулагч, нэвтрүүлгийн алба, Тайз чимэглэлийн албыг ОНТ-ын 1 дүгээр сувагт харьяалуулсан;
- ✦ 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/43 дугаар “МҮОНРТ-ийн Үндсэн үйлдвэрлэлийн нэгжүүдийн бүтэц, орон тоо, ажил, албан тушаалын жагсаалтыг түр хугацаагаар мөрдүүлэх” тушаал гарган дээрх тушаалыг хүчингүй болгосон.



2.39. Ерөнхий захирал 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Үндэсний зөвлөлд албан ёсоор байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх төслийг хүргүүлж, тус зөвлөлийн 2017 оны 8 дугаар сарын 22-ний өдрийн 48 дугаар тогтоолоор 680 байсан орон тооны дээд хязгаарыг MNB Спорт суваг, ОНТ-ийн 4 дүгээр суваг MNB world сувгууд болон “MNB-ийн хүүхдүүд” цэцэрлэгийг байгуулж, “Өргөн булаг” амралтын газрыг сувилал болгон үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор орон тоог 760 болгон баталсан боловч зарим салбар баталсан орон тоог хэтрүүлсэн байна.

2.40. Зарим салбар, нэгж баталсан орон тооны дээд хязгаарыг хэтрүүлээгүй ч орон тоог нэмүүлэх үндэслэлд тусгасан шинээр бий болох ажлын байрнууддаа ажилчид авалгүйгээр салбарын орон тоог нэмсэн байдалтай байна.

Хүснэгт № 8. МҮОНРТ-ийн 2017 оны орон тооны судалгаа

№	Салбар нэгж, албан тушаал	Орон тоо		Илүү дутуу
		48 дугаар тогтоолоор батлагдсан	Жилийн эцсийн байдлаар	
1	Ерөнхий захирал	1	1	-
2	Дэд захирал	1	1	-
3	Үндэсний зөвлөлийн НБД	1	1	-
4	Дотоод аудит	2	2	-
5	Уран сайхны удирдагч	1	1	-
6	Байгууллагын хөгжлийн газар	149	124	-25
7	Гадаад харилцааны хэлтэс	3	2	-1
8	Үндэсний телевиз	177	186	9
9	Монголын мэдээ	105	109	4
10	MNB Спорт	25	11	-14
11	MNB World	30	5	-25
12	Олон нийтийн радио	125	125	-
13	Техникийн төв	78	78	-
14	Маркетингийн хэлтэс	5	7	2
15	Санхүү, орлого бүрдүүлэлтийн хэлтэс	55	55	-
16	Захирлын туслах	2	1	-1
НИЙТ		760	709	-51

Эх сурвалж: МҮОНРТ-ийн Хүний нөөцийн алба

Байгууллагын бүтэц, дотоод зохион байгуулалтыг олон удаа өөрчилсөн нь салбарын батлагдсан цалингийн төсөв хэтрэх эрсдэлийг үүсгэсэн байна.

2.41. Орон тоо нэмүүлэх үндэслэлд тусгасан орон тоо болон 2017 оны жилийн эцэс, 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар орон тоонд судалгаа хийж, хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 9. МҮОНРТ-ийн 2017 онд орон тоог нэмэгдүүлсэн судалгаа

Орон тоо нэмүүлэх үндэслэл		2017 оны жилийн эцсийн байдлаар	2018 оны 1 дүгээр улирлын байдлаар
Салбар	Нэмэгдэх орон тоо		
MNB спорт	25	11	31
MNB world	30	5	23
MNB kids	17	12	12
“Өргөн булаг” сувилал	11	0	0
Эвент халл	4	0	0
НИЙТ	87	28	66

Эх сурвалж: МҮОНРТ-ийн Хүний нөөцийн алба

2.42. МҮОНРТ-ийн бүтэц, зохион байгуулалт 2017 онд олон удаа өөрчлөгдсөн, Санхүү, орлого бүрдүүлэлтийн хэлтсээс төсвийн гүйцэтгэлд хяналт тавиагүйгээс зарим салбарууд цалингийн санг дунджаар 179.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

2.43. Энэ нь “МҮОНРТ-ийн цалин хөлсний журам”-ын 1.4 дэхь хэсэгт “Ажилтнуудад нэмэгдэл хөлс, нэмэгдлийг олгохдоо салбарын захирлууд жилийн батлагдсан цалингийн санд багтаан олгох үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.



Хүснэгт № 10. Цалингийн санг 2017 онд хэтрүүлсэн салбарын судалгаа

(сая төгрөгөөр)

Салбар	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт
Үндэсний телевиз	1,737.9	2,033.8	295.9
Захиргаа дэмжих салбар	291.9	515.0	223.0
Захиргаа, үйлчилгээний хэлтэс	1,063.9	1,083.8	19.9

Эх сурвалж: Салбаруудын төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.44. Цаашид МҮОНРТ батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж, зохион байгуулалтын бүтцийг тогтвортой байлгаж, салбарын батлагдсан төсөв хэтрэх эрсдэлээс сэргийлэх шаардлагатай байна.



Дүгнэлт

МҮОНРТ-ийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитыг дараах 2 зорилтын хүрээнд төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

МҮОНРТ-ийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэхэд хийсэн дүгнэлт;

- МҮОНРТ-ийн үйл ажиллагааг хуулиар тодорхойлсон зорилго, үндсэн зарчимд нийцүүлэн хуульд заасан чиг үүргийн дагуу үр нөлөөтэй хэрэгжүүлж байна.
- Үндэсний зөвлөл хуулиар тодорхойлсон бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч зарим гишүүдийн идэвх, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.
- МҮОНРТ-ийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Үндэсний зөвлөлөөс МҮОНРТ-ийн хэмжээнд дагаж мөрдөх зарим журмыг төрийн хууль тогтоомжид нийцүүлэн батлан мөрдүүлж байгаа ч Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар тодорхойлсон статуст нийцсэн хуулийн зохицуулалт байхгүй байна.

МҮОНРТ-ийн санхүү, хөрөнгө, нөөцийг зохих ёсоор бүрдүүлж, үр ашигтай удирдаж байгаа эсэхэд хийсэн дүгнэлт;

- МҮОНРТ-ийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг тооцож авах Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны орлогыг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнд суурилан үндэслэлтэй төлөвлөж, өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.
- МҮОНРТ-ийн 50 жилийн ойн арга хэмжээнд 241.8 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, албан хаагчдаас шинээр нээгдсэн цэцэрлэгт 19.1 сая төгрөг, нийт 260.9 сая төгрөгийн хандивыг хүлээн авч, 224.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн боловч Үндэсний зөвлөлийн 2012 оны 13 дугаар тогтоолоор баталсан “МҮОНРТ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 6 дугаар бүлгийн 6.5 дахь хэсэгт заасны дагуу хандивын капиталаар бүртгээгүй байна.
- Эдийн засагч нарын ажлын байрны тодорхойлолтод санхүүгийн тайлан болон үйл ажиллагаанд шинжилгээ хийж, судалгаа дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан боловч тус чиг үүргийг зөвхөн орлого, зардлын өсөлт, бууралт болон төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүүг тооцоолох төдийгөөр хэрэгжүүлж, удирдлагын шийдвэр гаргахад нөлөөлөх хэмжээний иж бүрэн судалгаа, дүн шинжилгээ хийгээгүй, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тодорхойлоогүй байна.
- Бүтэц, зохион байгуулалтыг удаа дараа өөрчилснөөс үйл ажиллагааны тогтворгүй байдлыг бий болгож, салбарын батлагдсан цалингийн төсөв хэтрэх эрсдэлийг үүсгэсэн байна.



Зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зөрчил, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд:

1. МҮОНРТ-ийн урамшуулал болон бусад үйл ажиллагаа, Үндэсний зөвлөлөөс гаргасан тогтоол, зөвшөөрөл, баталсан төлөвлөгөө, гүйцэтгэл, Үндэсний аудитын газар болон хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлж, үр дүнг тооцож ажиллах;
2. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар тодорхойлогдсон статуст нийцсэн хууль, эрх зүйн зохицуулалт бий болгох, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулах замаар МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл болон Ерөнхий захирлын эрх, үүргийг ялгавартай, тодорхой болгох;
3. Үндэсний зөвлөл гишүүдийн идэвх, хариуцлагыг дээшлүүлэх.

МҮОНРТ-ийн Ерөнхий захиралд:

1. МҮОНРТ-ийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заалтын дагуу нэгдсэн судалгаа, өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнд суурилан төлөвлөж байх;
2. Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагад нийцүүлэн өөрийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан төлөвлөж, улсын төсвийн дэмжлэгийг бууруулж ажиллах;
3. Хандиваар бүрдүүлсэн 224.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу залруулж бүртгэх;
4. Албан хаагчдад урамшуулал олгож байгаа өнөөгийн журам, зохицуулалтыг үйл ажиллагааны бодит үр дүнтэй уялдуулан боловсронгуй болгон Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох зөвшөөрлийг авч батлах;
5. Эдийн засагч нарын үйл ажиллагааны давхардлыг арилгах, санхүүгийн хөрөнгө нөөцийг судалгаа, шинжилгээнд үндэслэн төлөвлөж, гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-г заасны дагуу үнэн зөв тайлагнаж хэвших.



МҮОНРТ-ээс ирүүлсэн санал



16061 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
11 дүгээр хороо, Хувьсгалчдын зам-3
Утас: (976-11) 32-16-14
E-mail: contact@mnv.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА

2018.05.03 № 2/432
танай _____ -ны/№ _____ -т

Тайлбар хүргүүлэх тухай

“МҮОНРТ-ийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад хавсралтад дурьдсан тайлбарыг хүргүүлж байна.

Үндэсний Аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газраас МҮОНРТ-ийн 2017 оны үйл ажиллагаанд Гүйцэтгэлийн аудит хийх үйл ажиллагаанд тоон мэдээллийг ашиглан тооцоолохдоо алдаа гаргаж, мөн холбогдох дотоод дүрэм журмуудтай дутуу танилцсанаас дараах буруу ташаа дүгнэлтүүдийг өгсөн байна.

1. 2017 оны ТӨСӨВ, Санхүүгийн тайлан балансаас тоон мэдээлэл авч харьцуулалт тооцоолол хийхдээ НББ-ийн мөнгөн болон аккурель сууриар илэрхийлсэн үзүүлэлтүүдийг хооронд нь хольж харьцуулалт тооцоолол хийснээс болж, **БҮЛЭГ. 2 –ын** доорх дүгнэлтүүдийг үндэслэлгүй гаргасан гэж үзэж байна.

- а. Радио телевизийн үйлчилгээний хөлсний тухай 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.10, 2.11 дугаар бүхий тооцоолол дүгнэлтүүд нь үндэслэлгүй буруу болсон байна. Үүнд:

Шалгалтын тайлан 2.4-д “МҮОНРТ 2017 онд **3,745,9 сая** төгрөгийг РТ-ийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 6,497,4 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг **2,751,5 сая** төгрөгөөр буюу **73,5%** давуулсан” гэжээ.

Гэтэл МҮОНРТ 2017 онд мөнгөн хөрөнгөөр **3,745.9 сая** төгрөгийн, **үр дүнгээр 5,479.3 сая** төгрөгийн телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг бүрдүүлэхээр төлөвлөж, төсвийн гүйцэтгэлээр мөнгөөр 4,703.8 сая төгрөг, **үр дүнгээр 6,497.4 сая** төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг мөнгөн хөрөнгөөр **957,907.0 төгрөг, үр дүнгээр 1,018.1 сая төгрөгөөр** давуулсан байна.

Аудит нь мөнгөн хөрөнгөөрх төсвийн төлөвлөгөөг үр дүнгээрх гүйцэтгэлтэй харьцуулснаас дүгнэлтийг буруу гаргажээ.

Шалгалтын тайлангийн 2.6-д “РТ-ийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний гүйцэтгэл батлагдсан төлөвлөгөөнөөс 2015 онд 1,511.9 сая төгрөгөөр, 2016 онд 1,824.2 сая төгрөгөөр давсан байхад гүйцэтгэлд дүн шинжилгээ, тооцоо судалгаа хийлгүй өмнөх оны төлөвлөгөөг 2016 онд 105,9 сая төгрөгөөр, 2017 онд 109,4 сая төгрөгөөр өсгөн төлөвлөжээ” гэж дүгнэсэн.

Гэтэл телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний гүйцэтгэл батлагдсан төлөвлөгөөнөөс 2015 онд 260.7 сая төгрөгөөр, 2016 онд 133.4 сая төгрөгөөр /төсвийн гүйцэтгэлээр/ тус тус давж биелэсэн.

102299



2.

Шалгалтын тайлангийн 2.7-д Дүрслэл №1 дээр 2015, 2016, 2017 оны мөнгөн хөрөнгөөрх төлөвлөгөөг тухайн онуудын үр дүнгээрх гүйцэтгэлтэй харьцуулж графикийг байгуулсан байна.

Үүнийг залруулбал:

а/ мөнгөн хөрөнгөөр /төсвийн гүйцэтгэлээр/ /мян. Төг/

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Өсөлтийн Хувь
2015	3,530,586.6	3,791,245.4	260,658.8	7,4 хувь
2016	3,636,482.6	3,769,877.6	133,395.0	3,6 хувь
2017	3,745,896.8	4,703,803.8	957,907.0	25,6 хувь

б/ Үр дүнгийн тайлангаар

/мян.төг/

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2015	4,517,145.7	5,042,484.9	525,339.2
2016	5,264,706.0	5,460,721.4	196,015.4
2017	5,479,267.1	6,497,374.5	1,018,107.4

Үүнээс үзэхэд телевизийн хураамжийн орлого 25,6 хувиар өссөн байтал 73.5 хувиар өссөн хэмээн хэтэрхий өндөр дүнгээр зөрүүтэй тооцоолол гаргажээ.

Шалгалтын тайлангийн 2.7-д “Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний төлөвлөгөөг 2017 оны 5 дугаар сард 73,0 сая төгрөгөөр тодотгон баталсан боловч гүйцэтгэлээр 2,751,5 сая төгрөгөөр давуулж, төлөвлөгөөнөөс давсан орлогыг дахин тодотгохгүйгээр шууд үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна” гэж дүгнэсэн.

Гэтэл телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний төлөвлөгөөг 2017 оны 5-р сард 73.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,745.9 сая төгрөгөөр баталж, 4,703.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 957.9 сая төгрөгөөр давж биелсэн.

в. Улсын төсвийн дэмжлэгийн талаар 2.14, 2.15, 2.16, 2.17 дугаар дүгнэлтүүдийг үндэслэлгүй гэж үзэж байна. Учир нь МҮОНРТ-нь Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн дагуу байгуулагдаж, статус нь ашгийн төлөө бус, төрийн бус, олон нийтийн цорын ганц байгууллага юм. Гэтэл 100% төрөөс санхүүждэг төрийн төсөвт байгууллагын төсөв тайлантай адилтгаж үзэж болохгүй юм.

Шалгалтын тайлангийн 2.15-д “Улсын төсвийн дэмжлэгээр ямар зардлыг санхүүжүүлдэг нь тодорхойгүй,” гэж дүгнэсэн байна.

МҮОНРТ нь 2017 онд нийт цалингийн зардалд 7.081.980,4 мянган төгрөг олгосны 85,9 хувийг 2017 онд олгосон Улсын төсвийн дэмжлэгээр 6.085.861,2 мянган төгрөгийг авч санхүүжүүлсэн. Үлдэгдэл 14,1 хувь буюу 998.559,2 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн.

Зардлын төрөл	2017 он	2017 оны Улсын төсвийн дэмжлэгээр	Өөрийн үйл ажиллагааны орлогоор
Цалин	7.081,9 сая төг	6.085,8 сая төг 85,9%	998,5 сая төг 14,1%
НДШимтгэл	1.652,9 сая төг		1.652,9 сая төг
ХХОАТ	687,4 сая төг		687,4 сая төг
Нийт дүн	9.422,2 сая төг	6.085,8 сая төг	3.336,4 сая төг



3.

Шалгалтын тайлангийн 2.16-д “Улсын төсвийн дэмжлэг нь МҮОНРТ-ийн алдагдлыг нөхөх зорилгоор олгогддог тул 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь 629,5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь тайлант онд зарцуулагдаагүй үлдсэн хөрөнгө юм.” гэжээ.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 629,5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өөрийн үйл ажиллагааны орлогоос бий болсон хуримтлал бөгөөд уг мөнгөөр 2018 оны 1 дүгээр сарын цалингийн зардлыг санхүүжүүлэх нөөц мөнгөн хөрөнгө юм.

Шалгалтын тайлангийн 2.17-д “Сангийн яам дараа жилийн улсын төсвийн дэмжлэгийг олгохдоо Төсвийн тухай хуулийн 7.7-д заасны дагуу өмнөх оны үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, улсын төсвийн дэмжлэгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна” гэжээ.

Гэтэл МҮОНРТ-д Улсын төсвийн дэмжлэг олгодог төрийн сангийн 100900011009 тоот дансанд 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үлдэгдэлгүй зарцуулсан учир Улсын төсвийн дэмжлэгийн дансанд үлдэгдэл байхгүй байгааг анхаараагүй.

с Хүний нөөцтэй холбоотой бүтэц орон тоо дотоод шилжилт хөдөлгөөний талаар судалгааг хангалтгүй хийснээр 2.59, 2.60 дугаар бүхий дүгнэлт болон Хүснэгт №11 тооцоолол буруу болсон.

- Захиргаа дэмжих салбарт нэмэлтээр "MNB" Word, "MNB" спорт сувгийн захирлууд, MNB World төслийн ажиллагсдын гүйцэтгэл орсон тул 76,882,115 төгрөг нэмэгдсэн.
- Захиргаа үйлчилгээний хэлтэст MNB" цэцэрлэгийн 12 хүний цалин нэмэгдсэн / 2017 оны 10-р сараас/ тул 19,9 сая төгрөг нэмэгдсэн.
- Ерөнхий захирлын А/50 тоот тушаалаар 2017 оны 4-р сараас Дундын албаны/ Тайз, зураг чимэглэлийн албаны 15 орон тоо, Кино, дуу оруулалтын 20, Дууны найруулагчид-15, Программын нэгдсэн хэлтсийн 23/ нийт 73 орон тоо Үндэсний телевизэд цалингийн сангийн хамт шилжин ирж тус салбарын цалингийн гүйцэтгэлд орсноос 295,925,493 төгрөг нэмэгдсэн.
- МҮОНРТ-ийн Цалингийн сан 2017 онд 45,600,347 төгрөгөөр хэмнэгдсэн.

Харин дүгнэлтэд Захиргаа дэмжих салбарын цалин **223,0 сая төгрөгөөр** хэтэрсэн гэдэг нь алдаатай тооцоолол болжээ. Ийм хэтрэлт огт байхгүй болно.

2. Ажиллагсдад олгосон шагнал урамшуулал тэтгэмжүүд нь 2005 оноос хойших Ерөнхий захирлын баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бүх дүрэм журмуудын дагуу олгогдсон болно. Жишээ нь сүүлийн 3 жилийн судалгааг гаргав.

Урамшуулал олгосон байдал

Ангилал	2014 он	2015 он	2016 он
Захиалгат нэврүүлэг, уран бүтээлийн урамшуулал	343,0 сая төг	144,6 сая төг	285,2 сая төг
Үр дүнгийн урамшуулал	86,1 сая төг		124,9 сая төг
Тайлан тэнцлийн урамшуулал	98,42 сая төг		38,5 сая төг
Нийт дүн	527,5 сая төг	144,6 сая төг	448,6 сая төг



4.

3. "МҮОНРТ-ийн санхүүгийн хөрөнгө нөөцийг үр ашигтай удирдаагүй байна." гэсэн дүгнэлт нь санхүүгийн баримтаар нотлогдохгүй байна. Үүнд:

1. 2017 оны Жилийн эцсийн санхүүгийн баланс тайланг СТОУС-/Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт/, НББОУС-/Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт/, НБББББ-/Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт/-ын дагуу тайлагнасан бөгөөд Үр дүнгийн тайлангаар тайлант үеийн үр 1,788.2 сая төгрөгийн ашигтай гарсан.

2. Ерөнхий захирал нь байгууллагын санхүүгийн хөрөнгө нөөцийг үр ашигтай удирдан зохион байгуулах үүргийн хүрээнд 2017 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэснийг тайландаа анхаарч үзээгүй орхигдуулсан. Үүнд:

- Өөрийн үйл ажиллагааны орлого болох телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хураамжийн шимтгэл 25% байсныг 15-23% болгон бууруулж шинэчилсэн гэрээ хийсэн үр дүнд хураамжийн орлогын төлөвлөгөө 73,0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

- Урьд ондуудад үүссэн 3 тэрбум төгрөгийн өр төлбөрөөс нийт 1.5 тэрбум төгрөгийн өр төлбөр барагдуулсан ба үүнээс гадаад өр төлбөр 557.5 сая төгрөг, дотоод өр төлбөр 78.5 сая төгрөг, захиалгат нэвтрүүлгийн /бэлэн мөнгөний гэрээ/ өр төлбөр 786.9 сая төгрөг, бартерийн 75.2 сая төгрөг, Хас банкны 17.0 сая төгрөгийн өр төлбөрийг тус тус барагдуулсан байна.

- Урьд онуудад үүссэн авлагаас 2017 онд нийт 221.3 сая төгрөгийн авлагыг цуглуулсан. Үүнд:Түрээс, захиалгат нэвтрүүлгийн авлагыг барагдуулсан.

- 2017 онд Төсөвлөсөн зардлаас дараах зардлуудын хэмнэж ажилласан байна.

--- Цалингийн зардал 347,0 сая төг
--- НДШимтгэл 15,5 сая төг
--- Бичиг хэргийн зардал 3,9 сая төг
--- Сургалтын зардал 66,7 сая төг
--- Харилцаа холбоо шуудан зардал 42,2 сая төг
--- Албан томилолт 89,6 сая төг
--- Уран бүтээл 405,4 сая төг

НИЙТ = 970,3 сая төгрөгийн зардлуудыг хэмнэж ажилласан болно.

- 2015-2017 оны тайлант үеийн цэвэр үр дүнгийн харьцуулалт

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он
Тайлант үеийн цэвэр үр дүн	-1,419,590,133	-812,233,325.1	1,788,220,104

- МҮОНРТ нь Улсын төсвийн орлогын тодорхой хэсгийг бүрдүүлдэг ХХОАТатварт 687.4 сая төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 1.652,9 сая төгрөг, 2017 онд нийтдээ 2,340.3 сая төгрөгийг шилжүүлж тайлант хугацаандаа өр төлбөргүй ажиллаж төсвийн орлогыг бүрдүүлэх үүргээ биелүүлсэн болно.



5.

Үүнээс гадна тайлангийн 1.38-д “Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд хяналтын зөвлөлийн гишүүн заавал орон тооны бус байна гэж заагаагүй учир цаашид хяналтын зөвлөлийн гишүүн бөгөөд дотоод аудитор гэсэн орон тоогоор ажиллуулах нь хуульд нийцэж илүү үр дүнтэй болохоор байна.” гэж дүгнэсэн нь хууль, журамд нийцэхгүй байна.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 28.2.-д “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Үндэсний зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгох бөгөөд Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална.”, МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн 2016.07.28-ны өдрийн 28 дугаар тогтоолоор баталсан “МҮОНРТ-ийн Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг сонгох, чөлөөлөх болон Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 1.5-д Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн нь Үндэсний зөвлөлийн төлөөлөл 1, үзэгч олон нийтийн төлөөлөл 2, нийт 3 гишүүнээс бүрдэнэ.” гэж заасантай зөрчилдөж байна.

Иймд шалгалтын тайланг дахин нягтлан үзэж Тайлан, Дүгнэлт, Зөвлөмждөө зохих засварыг оруулна уу.

Аливаа шалгалтыг явуулахдаа өмнө хийсэн шалгалтын мөрөөр гүйцэтгэсэн ажил, зохион байгуулсан арга хэмжээг судлаж, одоогийн байдалтай нь харьцуулан ололттой тал, дутагдалтай талуудыг нь тодорхойлж дүгнэлт хийдэг билээ.

Гэтэл МҮОНРТ-ийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн шалгалт хийсэн тухай 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Олон Нийтийн Радио, Телевизийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын талаархи төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлт”, “Үндэсний аудитын газрын дүгнэлт”, “Монгол улсын Сангийн яамны дүгнэлт”, “Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дүгнэлт”-үүдэд дурьдагдсан тухайн үеийн үйл ажиллагаа, санхүүгийн зөрчил дутагдлыг арилгасан байдал, одоогийн хүрсэн түвшин зэргийг харьцуулан судлаж бодит дүгнэлт хийсэнгүй.

Энэхүү шалгалтыг хийхдээ тус байгууллагын гүйцэтгэх удирдлагаас тайлбар аваагүй болно.

Иймд Үндэсний Аудитын Газрын шалгалтын тайланд зохих залруулгыг хийх шаардлагатай байгаа тул танайхаас гаргасан зөвлөмж, тайлантай холбоотой тайлбар, танилцуулгыг шалгалтын бүрэлдэхүүнд Ерөнхий захирал биечлэн танилцуулж, мэтгэлцэх хүсэлтэй байна.

Холбогдох хавсралтуудыг жагсаалтаар хүргүүлэв.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НИНЖОЖАМЦ

Үндэсний аудитын газрын тайлбар

МҮОНРТ-ийн Ерөнхий захирлын 2018 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 2/732 дугаар албан бичгээр нийт 54 заалт бүхий санал, тайлбар ирүүлсэн. Заалт тус бүрээр судалж үзэхэд 44 тайлбар, 11 санал ирүүлсэн байгаа бөгөөд тайлангийн төслөөс 7 асуудлыг хасч, 4 асуудлыг дараах байдлаар өөрчлөн найруулж тайлангийн төсөлд тусгалаа.

№	Санал авахаар хүргүүлсэн тайлангийн төсөлд тусгагдсан асуудлууд	МҮОНРТ-ээс ирүүлсэн санал	Саналыг хүлээн авч, тайлангийн төсөлд өөрчлөлт оруулсан асуудлууд
1	1.38. “Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд хяналтын зөвлөлийн гишүүн заавал орон тооны бус байна гэж заагаагүй учир цаашид хяналтын зөвлөлийн гишүүн бөгөөд дотоод аудитор гэсэн орон тоогоор ажиллуулах нь хуульд нийцэж илүү үр дүнтэй болохоор байна” гэж дүгнэсэн нь хууль, журамд нийцэхгүй байна.	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 28.2-д “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Үндэсний зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгох бөгөөд Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална”, МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн 2016.07.28-ны өдрийн 28 дугаар тогтоолоор баталсан “МҮОНРТ-ийн Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг сонгох, чөлөөлөх болон Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 1.5-д Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн нь Үндэсний зөвлөлийн төлөөлөл 1, үзэгч олон нийтийн төлөөлөл 2, нийт 3 гишүүнээс бүрднэ.” гэж заасантай зөрчилдөж байна. Тайлангаас хасуулах	Саналыг хүлээн авч тайлангийн төслөөс 1.38 дах хэсгийг хасав.
2	2.17. Сангийн яам дараа жилийн улсын төсвийн дэмжлэгийг олгохдоо Төсвийн тухай хуулийн 7.7-д заасны дагуу өмнөх оны үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, улсын төсвийн дэмжлэгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.	МҮОНРТ-д Улсын төсвийн дэмжлэг олгодог төрийн сангийн 100900011009 тоот дансанд 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үлдэгдэлгүй зарцуулсан учир Улсын төсвийн дэмжлэгийн дансанд үлдэгдэлгүй болно. Тайлангаас хасуулах	Саналыг хүлээн авч тайлангийн төслөөс 2.17 дах хэсгийг хасав.
3	2.21. МҮОНРТ 2017 онд захиалгат нэвтрүүлгийн орлогын 19.4%-ийг бартерын үйлчилгээгээр бүрдүүлж, санхүүгийн тайланд бүртгэсэн боловч бартерын үйлчилгээг зохицуулсан журам , эрх зүйн акт байхгүй байна.	Ерөнхий захирлын 2015.04.25-ны өдрийн 225 тоот тушаалаар батлагдсан “МҮОНРТ-д бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ын 1.6-д “Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа бараа, ажил, үйлчилгээ солилцоо /бартер/-ны хэлбэрээр хийх тохиолдолд энэхүү журмыг нэгэн адил баримтална” гэж заасныг мөрдлөг болгон ажиллаж байгаа болно. Тайлангаас хасуулах	Тайлангийн төслийн 2.21, 2.22 дах хэсэгт айруулгын өөрчлөлт оруулав.
4	2.31. МҮОНРТ-ийн ажилтан, албан хаагчдад үндсэн болон нэмэгдэл цалин хөлснөөс гадна Зуучийн, чанарын, захирлуудын зөвлөлийн болон төсөл хөтөлбөрийн гэх мэт урамшууллыг Ерөнхий захирлын тушаалаар баталсан дор дурьдсан журмуудыг үндэслэн олгосон байна. Үүнд:	Хөдөлмөрийн тухай хуулийн 47-р зүйлийн 47.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3.4 дэх хэсэгт “Үндсэн цалингийн сүлжээ, жишиг болон нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээ, шагнал, урамшуулал түүнийг олгох нөхцөл журам”-ыг баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Ерөнхий захирлын тушаалаар салбар тус бүрийн үйл ажиллагааны онцлог чиг үүргийн хүрээнд чанарын шагнал, урамшууллын журам боловсруулан 2016 оноос хойш /Ц.Оюундарь захиралын тушаалаар баталсан журмуудыг/ мөрдөн ажиллаж байна. Чанарын шагнал, урамшууллын 9 журам нь тус бүрийн харьяалах салбар нэгжийн ажлын онцлог, гүйцэтгэх үүргийн ялгавартай байдлаас шалтгаалан зөвхөн тухайн салбарын ажилтнуудад хамаарагдах тул давхардсан байдлаар ажилтанд урамшуулал олгогддоггүй.	Саналыг хүлээн авах боломжгүй тул тайлангийн төслийн 2.31 дэх хэсэгт найруулгын өөрчлөлт оруулав.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

	1. Дэмжих салбарын ажилтнуудын ажлын чанарыг үнэлэх, урамшуулал олгох журам 2. Техникийн төвийн ажилтнуудын ажлын чанарыг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам 3. Кино орчуулгын нэвтрүүлгийн албаны уран бүтээлчдийн ажлыг үнэлэх, чанарын шагнал урамшуулал олгох журам 4. Тайз чимэглэлийн албанаас хийж гүйцэтгэсэн уран бүтээлд чанарын шагнал урамшуулал олгох журам 5. Дууны найруулагч, нэвтрүүлгийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам 6. Маркетингийн менежерүүдийн ажлын чанарыг үнэлэх, урамшуулал олгох журам 7. ОНР-ийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам 8. Үндэсний телевизийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам 9. Монголын мэдээ телевизийн уран бүтээлийг үнэлэх, чанарын шагнал, урамшуулал олгох журам 10. МҮОНРТ-ээр нэвтрүүлэх зар сурталчилгаа болон нэвтрүүлгийг ивээн тэтгэх үйл ажиллагааг зохицуулах журмын 6 дугаар зүйл	Эдгээр журам нь тухайн салбар нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд ажлын гүйцэтгэл, чанар чансаа, үр өгөөжийг сайжруулах, ажилтны идэвх санаачлага, бүтээлч хүчин чармайлтыг урамшуулан дэмжих зорилготой. “МҮОНРТ-ийн цалин хөлсний журам”-д тусгагдаагүй бусад асуудлыг Монгол улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд шийдвэрлэнэ гэж “МҮОНРТ-ийн цалин хөлсний журам”-д заасан. “МҮОНРТ-ээр нэвтрүүлэх зар сурталчилгаа болон нэвтрүүлгийг ивээн тэтгэх үйл ажиллагааг зохицуулах журам” нь Иргэний хуульд үндэслэгдэж байгууллагын хооронд зуучилсны урамшуулал ба байгууллагын үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх, уран бүтээл төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг дэмжин урамшуулж байгууллагын санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн болно. Тайлангаас хасуулах	
5	2.41 Мөн Магнай трейд ХХК-тай гэрээ байгуулахдаа сонгон шалгаруулалтад оролцоходоо санал болгосон 3 хувийн хөнгөлөлт үзүүлэх талаар тусгаагүйгээс зөвхөн бэлэн мөнгөний худалдан авалтад хөнгөлөлт эдэлж 3.0 сая төгрөгийн хөнгөлөлт авах боломжийг алдсан байна.	Шатахуун нийлүүлэгч нь бэлэн мөнгө авахгүйгээр Бартер хийж байгаа тул 3%-ийн хөнгөлөлт үзүүлэх боломжгүй, зөвхөн бэлэн мөнгөөр тооцоо хийсэн тохиолдолд өгнө гэсэн болзолтой байсан тул гэрээнд энэ заалтыг оруулаагүй. Тайлангаас хасуулах	Саналыг хүлээн авч тайлангийн төслөөс 2.41 дэх хэсгийг хасав.
6	2.43 Ерөнхий захирал Л.Нинжамц Үндэсний зөвлөлийн шийдвэргүйгээр дээр дурьдсан журмын заалтыг зөрчин “MNB kids” цэцэрлэгийн барилгын засварын ажлыг	Кэнзай ХХК-тай 2017.09.11-нд 490 тоот 38,935,551 төгрөгийн цэцэрлэгийн цахилгааны монтаж гал дохиоллын гэрээ байгуулсан.	Тайлангийн төслөөс 2.43 дахь хэсгийг хасах үндэслэлгүй тул найруулгын өөрчлөлт оруулав.



МҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

	гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдөр Кэнзай ХХК-тай гэрээ байгуулан 33.2 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн байна.	“Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь 50.0 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй бол Үндэсний зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна” гэж заасан бөгөөд үнийн дүн нь 50,0 сая төгрөг хүрээгүй гэрээ байна. Тайлангаас хасуулах	
7	2.47 Аудитын явцад “MNB kids” цэцэрлэгийг ашиглалтад оруулах болон сонгон шалгаруулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд: 1. 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдөр цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийх компанийн сонгон шалгаруулалтаар Кэнзай тээвэр ХХК шалгаруулах дүгнэлт гарсан байхад гүйцэтгэгчээр нэг үүсгэн байгуулагчтай Кэнзай ХХК ажил гүйцэтгэсэн 2. Кэнзай тээвэр ХХК- руу нэмэлт гэрээ байгуулалгүйгээр 3.8 сая төгрөг шилжүүлсэн 3. “MNB kids” цэцэрлэгийн улсын бүртгэлийн гэрчилгээг Цэцэрлэгийн эрхлэгч Ж.Болортуяагийн нэр дээр бүртгүүлсэн. Ж. Болортуяа нь ажлаас чөлөөлөгдсөн	“MNB kids” цэцэрлэгийн засвар, тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар гаргасан Ерөнхий захирлын 2017.08.01-ний өдрийн А/105 дугаар тушаалын дагуу сонгон шалгаруулалтыг явуулж Кэнзай тээвэр ХХК шалгарсан бөгөөд тус компаниар нураалт угсралтын ажил хийлгэх 279 тоот гэрээ, заслын ажил хийлгэх 345 тоот гэрээнүүдийг байгуулж ажлыг хүлээн авч гэрээний үүрэг хэрэгжсэн. Тус компаниар засварын бүх ажлыг гүйцэтгүүлэх нь зохимжгүй байна гэж үзээд Ерөнхий захирлын 2017.08.31-ний өдрийн А/127 тоот тушаалаар тус цэцэрлэгийн Сантехникийн ажил, Цахилгаан монтаж холбоо, интернет, гал дохиоллын ажил, Агааржуулалтын ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг томилогдон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулалтыг явуулж : Сантехникийн ажилд-Сэрүүн хараат ХХК Цахилгаан монтаж холбоо, интернет, гал дохиоллын ажилд-Кэнзай ХХК Агааржуулалтын ажилд-Азухан ХХК тус тус шалгарч холбогдох гэрээнүүдийг байгуулан ажлыг гүйцэтгэн хүлээн авсан. Кэнзай ХХК нь Цахилгаан монтаж холбоо, интернет, гал дохиоллын ажилд үнийн саналаа ирүүлж өрсөлдөөд хамгийн бага үнийн саналаар шалгарсан тул гэрээ байгуулсан болно. 1. Кэнзай тээвэр ХХК-руу шилжүүлсэн 3,8 сая төгрөг нь хүүхдийн цэцэрлэгийн стандартын дагуу хийх гал дохиоллын ажлын хөлс байсан бөгөөд заслын ажлын үед заавал хийгдэх яаралтай ажил байсан тул тухайн ажлыг гүйцэтгэж байсан Кэнзай тээвэр ХХК гал дохиоллын ажлыг эрх бүхий мэргэжлийн компаниар туслан гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлж, ажил гүйцэтгэх гэрээний тайлан, гүйцэтгэлийг гаргаж өгсөн. Энэ ажлын хөлс 3,8 сая төгрөг нь Кэнзай ХХК-тай байгуулсан 38,935,551 төгрөгийн гэрээний үнийн дүнд багтаж байгаа болно. MNB kids” цэцэрлэгийн гэрчилгээний тухай. Үндэсний зөвлөлийн 2017.08.22-ны өдрийн 51 тоот тогтоолоор өгсөн зөвшөөрлийн дагуу Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.11.-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн санхүүжилтээр төлбөртэй цэцэрлэг ажиллуулж болно” гэж заасныг үндэслэн “MNB Kids” хожим нэрийг өөрчлөн “Эм Эн Би”-гийн хүүхдүүд” цэцэрлэгийг байгуулсан.	Саналыг хүлээн авч тайлангийн төслөөс 2.47 дахь хэсгээс 1 болон 3 дахь хэсгийг хасч, найруулгын өөрчлөлт оруулав. “Кэнзай тээвэр” ХХК-тай байгуулсан 38.9 сая төгрөгийн гэрээнээс гадна 3.8 сая төгрөгийг шилжүүлсэн нь нотлогдож байгаа тул 2 дахь хэсгийг хасах үндэслэлгүй байна.



М. Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

		Нийслэлийн Боловсролын газрын Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл/0002463/ авсан. Харин тус цэцэрлэг нь тусгай Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх ёстой гэсэн шаардлагыг Нийслэлийн боловсролын газар, БГД-ийн Боловсролын хэлтэс тавьсан. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 10.1.-д зааснаар Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг гэсэн хэлбэртэй байна гэсэн шаардлага тавьж эхэлсэн бөгөөд манай байгууллага нь төрийн байгууллага биш учир “Эм Эн Би кидс цэцэрлэг” Боловсрол сургалтын байгууллага гэсэн нэр дээр Сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ/регистр 8256055/ авсан болно. Уг гэрчилгээнд Эрхлэгчээр Жамц овогтой Болортуяаг томилсныг бүртгүүлсэн. Үүсгэн байгуулагчаар МҮОНРТ, өмчийн хэлбэр нь Олон нийтийн оролцоотой гэж улсын бүртгэлд бүртгэгдсэн. Хууль зөрчөөгүй. Ж.Болортуяаг 2017.08.23-ны 451 тоот тушаалаар цэцэрлэгийн эрхлэгчээр томилсон. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.11, 10.1 дэх заалтууд хоорондоо зөрчилдөж, аж ахуйн нэгж байгууллагын цэцэрлэгийн эрх зүйн зохицуулалт дутмаг байснаас аргагүй эрхэнд манай байгууллага цэцэрлэгийн үйл ажиллагаагаа явуулахын тулд “Эм Эн Би кидс цэцэрлэг” Боловсрол сургалтын байгууллага гэсэн нэр дээр гэрчилгээг гаргуулсан. Санхүүжилт нь манай байгууллагын дансанд орж байгаа болно. Тус цэцэрлэгийн 2018 оны санхүүжилт/Хувьсах зардал/-ийг улсын төсвөөс авахаар Нийслэлийн боловсролын газар, Нийслэлийн засаг даргад хүсэлтээ хүргүүлж, төсвөөс санхүүжилт хуваарилагдсан. Үндэсний зөвлөлд хүсэлт хүргүүлсний дагуу МҮОНРТ-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээнд “Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулах” гэсэн заалт нэмэх тухай Үндэсний зөвлөлийн 2018.03.29-ний өдрийн 17 тоот тогтоол гарсан. Тайлангаас хасуулах	
9	2.49 ОНРТ ТХ-ийн 16.2-т ОНРТ-ийн эд хөрөнгө захиран зарцуулахдаа энэ хуулийн 3.2-т заасан зорилгыг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ. Гэж заасныг зөрчин Ерөнхий захирал нь ҮЗ-ийн гишүүн, МСНЭ-ийн холбооны ерөнхийлөгч Д.Галааридтай 2017.07.06-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж 20,0 сая төгрөг шилжүүлжээ. ҮЗ-ийн гишүүний тэргүүлдэг МСНЭ Холбоо ТББ-тай БНХУ-ын сэтгүүлчдийг хүлээн авах зардалд зориулж 20,0 сая төгрөгийн гэрээ хийсэн нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж, олон нийтийн хөрөнгийг	Энэхүү асуудлаар Монгол улсын иргэн гаргасан гомдлоор Авлигатай тэмцэх газар шалгалт хийж, Нийслэлийн Прокурорын 2018 оны 02 дугаар сарын 08-ны №48 тоот тогтоолоор хууль зөрчөөгүй гэж тогтоосон тул 20 сая төгрөг буцааж төлүүлэх актаасаа татгалзахыг хүсье. Тогтоолд... Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал Л.Нинжамц нь Солонгосын сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, салбар зөвлөлийн тэргүүлэгч, сэтгүүлчдийн 15 хүний бүрэлдэхүүнтэй хоёр талын хамтын ажиллагааны чиглэлээр туршлага солилцох, Үндэсний их баяр наадам үзэх, Монгол улсын түүх соёлыг Ази тивд сурталчлан таниулах зорилгоор айлчлан ирж байгаатай холбогдуулан ажил үйлчилгээ үзүүлэх талаар “Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл” ТББ-ын тэргүүн Б.Галааридтай 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр “Хамтран ажиллах гэрээ” байгуулж гэрээний дагуу 20 сая төгрөгийг “Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл” ТББ-д шилжүүлсэн байна. “Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл” ТББ-ын тэргүүн Б.Галаарид нь 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээнд заасны дагуу	Хууль хяналтын байгууллагаар шалгагдсан асуудал тул саналыг хүлээн авч, тайлангийн төслөөс 2.49, 2.50 дах хэсгийг хасав.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

	зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчилтэй байгаа тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.	шилжүүлсэн 20 сая төгрөгийг Солонгосын сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, салбар зөвлөлийн тэргүүлэгч, сэтгүүлчдийн бүрэлдэхүүнтэй 15 хүнийг 8 хоногийн хугацаатай Монгол улсад хүлээн авах ажиллагаанд зарцуулж, зарцуулалтын тайлан, санхүүгийн анхан шатны баримтуудыг МҮОНРТ-ийн санхүүгийн албанд хүлээлгэн өгч 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдөр гэрээг дүгнэсэн байна. Үүнээс үзэхэд МҮОНРТ-ийн Ерөнхий захирал Л.Нинжамц нь “Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл” ТББ-ын тэргүүн Б.Галааридтай хамтран ажиллах гэрээ байгуулан өөрийн бүрэн эрхийн хэмжээнд 20 сая төгрөгийг шилжүүлсэн үйлдэл нь Эрүүгийн хуулинд хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, хэрэг бүртгэлийн хэрэг нээх үндэслэлгүй байна... гэжээ. /Тогтоолыг хавсаргав/ “ОНРТ ТХ-ийн 16.2.Олон нийтийн радио, телевиз эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа энэ хуулийн 3.2-т заасан зорилгыг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ., 3.2.Олон нийтийн радио, телевизийн зорилго нь үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход оршино. хэмээн заасан.” Мөн хуулийн 3.3.-д “Олон нийтийн радио, телевиз гадаадын сонсогч, үзэгчдэд зориулсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, Монгол Улсын гадаад, дотоод бодлогын талаар мэдээлэх, Монгол орныг дэлхий дахинд сурталчлах, таниулах чиглэлийн хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэж түгээнэ” гэж заасан байдаг. Энэ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа болно. Гэхдээ тухайн байгууллага нь нийгмийн харилцаанд оролцож байгаа хуулийн этгээдийн хувьд янз бүрийн Эрх зүйн харилцаанд оролцож, эрх үүрэг хэрэгжүүлж байдаг бөгөөд Ерөнхий захирал нь хуульд харшлаагүй, хуулиар хориглоогүй, Иргэний хуульд заасан аливаа гэрээг байгуулж болно гэж үзэж байна. Зөвхөн ОНРТ-ТХ-ыг хэрэгжүүлдэг байгууллага гэж үзэх нь хэтэрхий явцуу ойлголт болох юм. Тайлангаас хасуулах																	
10	2.51 МҮОНРТ-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.5.17, 4.8.6.1 дэх заалтуудад Үндэсний зөвлөлийн дарга, гишүүд, МҮОНРТ-ын захирал нь Үндэсний зөвлөлөөс олгосон эрхийн дагуу олон нийтийн радио, телевизийг гадаад дотоодод төлөөлнө гэж заасныг зөрчин Үндэсний зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр Ерөнхий захирал Л.Нинжамц 2017 оны 12 дугаар сард БНХАУ явсан. Мөн дараах гишүүд МҮОНРТ-ийг төлөөлж 21.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: - Үндэсний зөвлөлийн гишүүн Х.Чилаажав Япон 7.0 сая төгрөг,	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 31.6.7 дахь заалтын дагуу Ерөнхий захирал нь МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 40 тоот тогтоолоор, Үндэсний зөвлөлийн дарга Б.Энхмандахын баталсан төсвийн хүрээнд гадаад улсад ажил үүрэг гүйцэтгэсэн. Мөн Үндэсний зөвлөлийн даргын баталсан төсвийн хүрээнд дараах гадаад томилолтуудад санхүүжилт олгосон. Тайлангаас хасуулах <table border="1"> <thead> <tr> <th>Нэрс</th><th>Хаана</th><th>Зөвшөөрөл олгосон, төсөв баталсан</th><th>Огноо /төсөв, тогтоол гарсан/</th></tr> </thead> <tbody> <tr> <td>ҮЗ-ийн гишүүн – Х.Чилаажав</td><td>Токио</td><td>ҮЗ-ийн дарга Б.Энхмандах</td><td>2017.08.02</td></tr> <tr> <td>ҮЗ-ийн гишүүн – 3.Энхболд</td><td>Токио</td><td>ҮЗ-ийн дарга Б.Энхмандах</td><td>2017.08.02</td></tr> <tr> <td>ҮЗ-ийн гишүүн 3.Энхболд</td><td>Бээжин-яваагүй</td><td>ҮЗ-ийн дарга Б.Энхмандах</td><td>2017.10.19</td></tr> </tbody> </table>	Нэрс	Хаана	Зөвшөөрөл олгосон, төсөв баталсан	Огноо /төсөв, тогтоол гарсан/	ҮЗ-ийн гишүүн – Х.Чилаажав	Токио	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.08.02	ҮЗ-ийн гишүүн – 3.Энхболд	Токио	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.08.02	ҮЗ-ийн гишүүн 3.Энхболд	Бээжин-яваагүй	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.10.19	Тайлангийн төслийн 2.51 дэх хэсэгт Үндэсний зөвлөлийн гишүүн 3.Энхболд, Ж.Соёл-Эрдэнэ нар БНХАУ явсан талаар дурдаагүй болно. Ерөнхий захирал БНХАУ явсан талаарх асуудлыг хасч, бусад асуудалд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Нэрс	Хаана	Зөвшөөрөл олгосон, төсөв баталсан	Огноо /төсөв, тогтоол гарсан/																
ҮЗ-ийн гишүүн – Х.Чилаажав	Токио	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.08.02																
ҮЗ-ийн гишүүн – 3.Энхболд	Токио	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.08.02																
ҮЗ-ийн гишүүн 3.Энхболд	Бээжин-яваагүй	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.10.19																

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

	- Үндэсний зөвлөлийн гишүүн З.Энхболд Япон 7.0 сая төгрөг, - Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Нямсамбуу БНХАУ 2.5 сая төгрөг, - Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Батбаяр БНХАУ 2.5 сая төгрөг, - Үндэсний зөвлөлийн гишүүн С.Мягмар Турк улс руу 2.4 сая төгрөг.	<table border="1"> <tr> <td>ҮЗ-ийн гишүүн Ж.Соёл-Эрдэнэ</td><td>Бээжин-яваагүй</td><td>ҮЗ-ийн дарга Б.Энхмандах</td><td>2017.10.19</td></tr> <tr> <td>ҮЗ-ийн гишүүн С.Мягмар</td><td>Турк</td><td>ҮЗ-ийн дарга Б.Энхмандах</td><td>2017.11.23</td></tr> <tr> <td>Ерөнхий захирал Л.Нинжжамц</td><td>БНХАУ Хайнан</td><td>ҮЗ-ийн 40 тоот тогтоолтой, ҮЗ-ийн даргын баталсан төсөвтэй</td><td>2017.05.30</td></tr> </table>	ҮЗ-ийн гишүүн Ж.Соёл-Эрдэнэ	Бээжин-яваагүй	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.10.19	ҮЗ-ийн гишүүн С.Мягмар	Турк	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.11.23	Ерөнхий захирал Л.Нинжжамц	БНХАУ Хайнан	ҮЗ-ийн 40 тоот тогтоолтой, ҮЗ-ийн даргын баталсан төсөвтэй	2017.05.30	
ҮЗ-ийн гишүүн Ж.Соёл-Эрдэнэ	Бээжин-яваагүй	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.10.19												
ҮЗ-ийн гишүүн С.Мягмар	Турк	ҮЗ-ийн дарга Б.Энхмандах	2017.11.23												
Ерөнхий захирал Л.Нинжжамц	БНХАУ Хайнан	ҮЗ-ийн 40 тоот тогтоолтой, ҮЗ-ийн даргын баталсан төсөвтэй	2017.05.30												
11	2.54 Байгууллагын бүтцийг өөрчлөхдөө ул суурьтай хандахгүйгээр шийдвэр гарган бүтэц, зохион байгуулалтыг олон удаа өөрчилсөн нь үйл ажиллагааны тогтворгүй байдал бий болгож, батлагдсан төсвийг төлөвлөсний дагуу зарцуулахгүй байх эрсдэлийг үүсгэсэн байна. Ерөнхий захирал нь МҮОНРТ-ийн бүтцийг өөрчлөх талаарх дээрх шийдвэрүүдийг гаргасны дараа 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Үндэсний зөвлөлд албан ёсоор бүтэц зохион байгуулалтын төслийг хүргүүлж, тус зөвлөлийн 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 48 дугаар тогтоолоор 680 байсан орон тооны дээд хязгаарыг MNB Спорт суваг, ОНТ-ийн 4 дүгээр суваг MNB world сувгууд болон “MNB-ийн хүүхдүүд” цэцэрлэгийг байгуулж, “Өргөн булаг” амралтын газрыг сувилал болгон үйл ажиллагааг өргөжүүлэх зорилготойгоор 760 болгон баталсан байна. МҮОНРТ нь 2017 оны жилийн эцсийн байдлаар зарим салбар Үндэсний зөвлөлийн баталсан орон тооноос хэтрүүлсэн байна.	Бүтцийг 2017 онд Үндэсний зөвлөлөөс 1 удаа өөрчилж баталсан. Ерөнхий захирлын тушаалаар 1 удаа дотоод бүтцийг туршилтаар мөрдөхөөр шийдвэрлэсэн тул олон удаа өөрчилсөн гэж үзэх үндэслэлгүй байна. “Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 24.1.6-д Олон нийтийн радио, телевизийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох гэж заасан бөгөөд Ерөнхий захирал нь Үндэсний зөвлөлөөс тогтоосон орон тооны дээд хязгаарт багтаан, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 31.6.6 дахь хэсэг, “МҮОНРТ-ийн цалин хөлсний журмын “ 3.1-д “Байгууллагын эрхэм зорилго, зорилтын хэрэгжилтийг хангахуйц, үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад зайлшгүй шаардлагатай, байх ёстой ажил, албан тушаалыг хэрэгцээт орон тоогоор тодорхойлж “МҮОНРТ-ийн ажил, албан тушаалын жагсаалт” баримт бичгийг оны эхэнд Ерөнхий захирлын тушаалаар батлан мөрдөнө” гэж заасны дагуу Ерөнхий захирал өөрийн эрх хэмжээний хүрээнд дотоод бүтэц, ажил албан тушаалын жагсаалтаа батлан ажилласан болно. Зарим салбарт хэтэрсэн гэдэгт “Үндэсний телевизэд 9 орон тоо, Монголын мэдээ сувагт 4 орон тоо хэтэрсэн бусад хэсэгт хэтрээгүй байна. Үндсэн дүнгээрээ 51 орон тоонд ажилтан аваагүй байна. Үндэсний Телевизэд “Өдрийн хөтөлбөр” зэрэг шинэ сүлжээний дагуу шинэ нэвтрүүлэг хөтөлбөр бий болсонтой холбоотойгоор хүний нөөцөөр хангах шаардлагын үүднээс холбогдох уран бүтээлчдийг авч ажиллуулах болон салбар хооронд шилжүүлэн ажиллуулсан. Монголын мэдээ сувагт Дундын алба буюу Найруулагч нэвтрүүлэгчдийн албанаас 4 нэвтрүүлэгч орон тоо цалингийн сантайгаа шилжин ирснээр 4 орон тоо нэмэгдсэн. Найруулга, агуулгын өөрчлөлт хийлгэх	Саналыг хүлээн авч 2.54 дэх хэсэгт найруулгын өөрчлөлт оруулав.												
12	ДҮГНЭЛТ-ээс Үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байгаа 2 аудиторыг хяналтын зөвлөлийн гишүүн бөгөөд дотоод аудитор гэсэн орон тоогоор ажиллуулах нь дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж илүү үр дүнтэй болох боломжтой байна.	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 28.2-д “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Үндэсний зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгох бөгөөд Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална.”, МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн 2016.07.28-ны өдрийн 28 дугаар тогтоолоор баталсан “МҮОНРТ-ийн Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг сонгох, чөлөөлөх болон Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 1.5-д Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн нь Үндэсний зөвлөлийн төлөөлөл 1, үзэгч олон нийтийн төлөөлөл 2, нийт 3 гишүүнээс бүрдэнэ.” гэж заасантай зөрчилдөж байна.	Саналыг хүлээн авч Дүгнэлтээс хасав.												

Хавсралтууд

Хавсралт № 1

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

(сая төгрөгөөр)

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчил гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	МҮОНРТ-ийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг тооцож авах Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.		Зөвлөмж өгөх	Санхүү, орлого бүрдүүлэлтийн хэлтэс, Нэгдсэн төсвийн эдийн засагч	Санхүү, бүрдүүлэлтийн хэлтсийн дарга болон ажилтнууд, П.Оюунсүрэн
2	Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны орлогыг өмнөх оны гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнд суурилан үндэслэлтэй төлөвлөж, өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна.		Зөвлөмж өгөх	Санхүү, орлого бүрдүүлэлтийн хэлтэс, Нэгдсэн төсвийн эдийн засагч	Санхүү, бүрдүүлэлтийн хэлтсийн дарга болон ажилтнууд, П.Оюунсүрэн
3	МҮОНРТ-ийн 50 жилийн ойн арга хэмжээнд 241.8 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, албан хаагчдаас шинээр нээгдсэн цэцэрлэгт 19.1 сая төгрөг, нийт 260.9 сая төгрөгийн хандивыг хүлээн авч, 224.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн боловч Үндэсний зөвлөлийн 2012 оны 13 дугаар тогтоолоор баталсан “МҮОНРТ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 6 дугаар бүлгийн 6.5 дахь хэсэгт заасны дагуу хандивын капиталаар бүртгээгүй байна.		Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч, Санхүү, орлого бүрдүүлэлтийн хэлтсийн дарга	Т.Анхтуяа, Ц.Амарбаясгалан
4	Эдийн засагч нарын ажлын уялдаа, холбоо муу байгаагаас үйл ажиллагааны зардлыг тооцоо судалгаагүйгээр төлөвлөж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй байна		Зөвлөмж өгөх	Нэгдсэн төсвийн эдийн засагч, Эдийн засагч	П.Оюунсүрэн, Г.Сарангэрэл
5	Үндэсний зөвлөлийн шийдвэргүйгээр байгууллагын дотоод бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн		Зөвлөмж өгөх	Ерөнхий захирал	Л.Нинжжамц
Нийт дүн					

Тайланг баталгаажуулсан тушаал



2018 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дах заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам батлах тухай" журмын 4.2, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл, "Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз"-д тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлага болон зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл /Б.Энхмандах/, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз /Л.Нинжамц/-д зөвлөсүгэй.
4. Албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.
5. Аудитын тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaal\2018\0620GAG2.Docx

073891

This image shows a full page of white paper with horizontal dotted lines, typical of primary school writing paper. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.